



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Гүйцэтгэлийн аудитын тайлан

**Улс, орон нутгийн төсөв, МУХС, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2008 онд хийсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн**

*(Дэд бүтцийн салбар)*



**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛД  
ТАВИХ ХЯНАЛТ, ГЭРЭЭ ДҮГНЭХ АЖЛЫН ЧАНАР  
ХАНГАЛТГҮЙ БАЙНА**

Улаанбаатар хот

# Агуулга

<b>Тайланг бэлтгэсэн:</b>	Товчилсон үгсийн жагсаалт	2
ҮАГ-ын Хоёрдугаар газар	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
Газрын захирал Д.Ганбилэг	<b>Бүлэг 1</b>	
Аудитын менежер Х.Баярмаа	<b>Хөрөнгө оруулалтын хэтийн бодлого, төлөвлөгөөг мөрдөж ажиллаагүй байна</b>	
Ахлах аудитор С.Оюунгэрэл	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндэслэл хангалтгүй байна	4
Аудитор Ц.Цэрэнхүү Г.Юра Г.Нямдорж	Эх үүсвэр нь шийдэгдээгүй шугамд их хэмжээний хөрөнгө зарцуулжээ	6
Шинжээч У.Баярмаа	Хөрөнгө оруулалтын зарим арга хэмжээг МУХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх шаардлага үүссэн байна	8
	<b>Бүлэг 2</b>	
	<b>Худалдан авах ажиллагаанд хуулийг жигд баримтлаагүй байна</b>	
2009 оны 6 дугаар сар	Тендерийн хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй байна	10
	Зарим ажлын гүйцэтгэгчийг зохих журмын дагуу шалгаруулаагүй байна	12
	<b>Бүлэг 3</b>	
Уг тайланг ҮАГ-ын Веб сайтаас үзнэ үү: <a href="http://www.mnao.pmis.gov.mn">www.mnao.pmis.gov.mn</a>	<b>Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл хангалтгүй байна</b>	
	Гэрээ байгуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай байна	14
	Гэрээний гүйцэтгэлийг дүгнэх ажил үр нөлөөгүй болжээ	15
	Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй хариуцлага тооцоогүй байна	19
	<b>Бүлэг 4</b>	
	<b>Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна</b>	
	Төрийн байгууллагуудын ажлын уялдаагүйгээс хөрөнгө оруулалтын үр ашиг буурч байна	21
	Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг хянах дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоо бүрдээгүй байна	22
	Дүгнэлт	24
	Холбогдох байгууллагын санал	25
	Тайлбар	31
	Зөвлөмж	32
	Хавсралт	33
	Ерөнхий аудиторын тушаал	37
<b>ХАЯГ:</b> Үндэсний аудитын газар Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46 Монгол Улс		

## Товчилсон үгсийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, эрчим хүчний яам
ТЭХЯ	Түлш, эрчим хүчний яам
ЗТБХБЯ	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам
МУХС	Монгол Улсыг хөгжүүлэх сан
ҮХЯ	Үйлдвэр, худалдааны яам
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
ОХУ	Оросын Холбооны Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ТӨХ	Төрийн өмчийн хороо
УМХГ	Улсын мэргэжлийн хяналтын газар
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
ЭХСХТ	Эрчим хүчний судалгаа, хөгжлийн төв
ЭХГ	Эрчим хүчний газар
АМГТХЭГ	Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар
СЭХҮТ	Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв
ШУТЗ	Шинжлэх ухаан, технологийн зөвлөл
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТЭХ	Түлш, эрчим хүч
УБЦТС	Улаанбаатар-Цахилгаан түгээх сүлжээ
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
БУА	Барилга угсралтын ажил
УЦС	Усан цахилгаан станц
АЗХСТ	Авто замын хяналт судалгааны төв
АЗГ	Авто замын газар
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ГХБГЗЗГ	Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар
ТБУСТХ	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль
ДСЦТС	Дархан-Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ
ДШС	Дулааны шугам сүлжээ
ШС	Шугам сүлжээ
ИТА	Инженер техникийн ажилтан
ЗБА	Зам барилгын ажил
БХБА	Барилга, хот байгуулалтын алба

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2009 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн, Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд энэхүү аудитыг хийв.

Дэд бүтцийн салбарт улсын төсөв, МУХС, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2008 онд хийсэн хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагнал, түүний үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдлээ.

Аудитад ЭБЭХЯ, ЗТБХБЯ, ЭХГ, АМГ, ГТГ, ИНЕГ, АЗГ, ГХБГЗЗГ болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр дэд бүтцийн салбарт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр, холбогдох бусад байгууллагын 2008 оны хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг хамруулав.

Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Гүйцэтгэлийн шалгалтын журам, Гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөөг мөрдлөг болгон холбогдох байгууллагуудын мэргэжилтнүүдтэй ярилцлага хийх, судалгаа, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг гүйцэтгэлийн аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

## Бүлэг 1

### Хөрөнгө оруулалтын хэтийн бодлого, төлөвлөгөөг мөрдөж ажиллаагүй байна

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндэслэл хангалтгүй байна

**Эрдэс баялаг, эрчим хүчний яам:**

1.1 Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуульд Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд “эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газраас дэвшүүлж байгаа богино болон дунд хугацааны хэтийн зорилтуудыг тусгах” шаардлагыг заасан байна.

1.2 Мөн хуулийн 33.2.4-т “Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсөвт улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг хөрөнгө оруулалтын төсөл бүрээр” тусгахаар заажээ.

1.3 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн /цаашид тендерийн хууль гэх/ 48.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн төсвийн хүрээнд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг эцэслэн боловсруулж, улсын төсөв батлагдсанаас хойш 45 хоногийн дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ” гэж заасан байна.

1.4 2008 оны Улсын төсвийн тухай хууль, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2008 оны төсвийн тухай хуулиар түлш, эрчим хүчний салбар болон ашигт малтмал, газрын тосны салбарт нийт 90,303.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөснийг хүснэгтээр үзүүлбэл: (сая төгрөгөөр)

/Хүснэгт №1/

Үзүүлэлт	Улсын төсөв		Хөгжүүлэх сан		Нийт дүн		Дүнд эзлэх хувь
	Объект тоо	Дүн	Объект тоо	Дүн	Объект тоо	Дүн	
ЦДАШ, дэд станц	40	38 227,0	11	24 876,0	51	63 103,0	69,9
Сэргээгдэх эрчим хүч					0	-	0,0
Дулааны станц, дулааны шугам сүлжээ	3	1 500,0	3	16 650,0	6	18 150,0	20,1
Гадаад зээлийн дотоод эх үүсвэр	3	1 840,0			3	1 840,0	2,0
ЭХ-ний зураг төсөл, ТЭЗҮ	2	1 985,0			2	1 985,0	2,2
Түлш			2	1 065,0	2	1 065,0	1,2
<b>ТЭХ-ний салбарын дүн</b>	<b>48</b>	<b>43 552,0</b>	<b>16</b>	<b>42 591,0</b>	<b>64</b>	<b>86 143,0</b>	<b>95,4</b>
Эрдэс баялаг	6	4 160,0			6	4 160,0	4,6
<b>Нийт дүн</b>	<b>54</b>	<b>47 712,0</b>	<b>16</b>	<b>42 591,0</b>	<b>70</b>	<b>90 303,0</b>	<b>100,0</b>

1.5 ТЭХ-ний салбарт 166,107.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий хөрөнгө оруулалт, их засварын 105 ажлыг Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуульд

тусгуулахаар төлөвлөсөн боловч УИХ-аас 64 ажилд 86,143.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, их засварын ажлыг гүйцэтгэхээр (үүнд, 40461.0 сая төгрөгийн 28 ажлыг шинээр нэмж, 121,579.8 сая төгрөгийн 69 ажлыг хасан, 12 ажилд зарцуулах хөрөнгийн дүнг 2,296.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 3 ажилд зарцуулахаар төлөвлөсөн хөрөнгийн дүнг 1,670.7 сая төгрөгөөр бууруулж) баталжээ.

1.6 Түлш, эрчим хүчний салбарт хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын ТЭЗҮ-ийг хэлэлцэн хянаж, батлах үүрэг бүхий салбарын эрдэмтэн, судлаачдын бүрэлдэхүүнтэй ШУТЗ 2008 онд 7 удаагийн хурлаар 50 орчим асуудлыг хэлэлцэн, дүгнэлт гаргажээ.

1.7 ЦДАШ-ын БУА-ын хөрөнгө оруулалтыг төлөвлөсөн байдлыг зарим материалын үнээр харьцуулан үзвэл оролцогч компаниудын өртгөөс нийт 4,054.3 сая төгрөгөөр илүү тооцсон ДСЦТС, Нью прогресс, Алтай трест, Эрчмийн ундраа, ЭХБУТ, Баянконстракшн зэрэг 6 компани тендерт ялсан байна.

1.8 2007 онд импортын өндөр хүчдэлийн 1 ш төмөр бетон шон 715.0 мянган төгрөг, 10 квт-ын трансформатор 26.3 сая төгрөг, 15 квт-ын трансформатор 29.1 сая төгрөгийн үнэтэй байжээ. Мөн Ган хийц ХХК 2007 онд ЗТБ-35.04 тулгуурыг 715.0-893.0 мянган төгрөгөөр худалдаж байжээ.

1.9 Гэтэл дээрх компаниуд 2007 онд 1 ш төмөр бетон шонг 1,711.0-2,500.0 мянган төгрөг, 10 квт-ын трансформаторыг 35.0 сая төгрөг, 15 квт-ын трансформаторыг 60.0 сая төгрөгөөр үнэлэн харьцангуй өндөр үнээр төсөв зохиож, тендерт ялсан байна. Тухайлбал, ЦДАШ-ын:

1. Алтай трест ХХК-ийн гүйцэтгэсэн Дөргөний УЦС-Мянгад сумын 72.4 км ажлын төсвөөс 333.3 сая төгрөг;
2. Нью прогресс ХХК-ийн гүйцэтгэсэн Мянгад-Манхан сумын 121 км ажлын төсвөөс 774.7 сая төгрөг;
3. Нью прогресс ХХК-ийн гүйцэтгэсэн Зэрэг-Дарви сумын 67 км ажлын ЗТБ35-18, 21 тулгууруудын үнийн зөрүүгээс 141.7 сая төгрөг;
4. ДСЦТС ХК-ийн гүйцэтгэсэн Өндөрхаан-Баруун Уртын 230 км ажлын ЗБ110-1 маркийн төмөр бетон шонгийн үнийн зөрүүгээс 750.9 сая төгрөг;
5. Алтай трест ХХК-ийн гүйцэтгэсэн Улаангом-Малчин сумын 134 км ажлын төсвөөс 254.9 сая төгрөгийг тус тус хэмнэх боломж байжээ.

1.10 Барилга захиалагчийн дүрмийн “Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг бага зардлаар илүү үр дүнд хүрэх шаардлагад нийцүүлэн боловсруулах” заалт бүрэн хэрэгжихгүй, үнэлгээний хорооны гишүүдийн дунд мэргэшсэн төсөвчин байдаггүй, үнэлгээг нарийвчлан хянах тогтолцоо байхгүй байна.

1.11 ЦДАШ-ын БУА-ыг техникийн нөхцөл, зураг төсөл дутуу, зохих ёсоор төсөв хийгдээгүй байхад төлөвлөж эхлүүлснээс ажил удаашрах, нэмэлт санхүүжилт шаардагдах явдал нилээд гарчээ. Тухайлбал,

- Таван толгой –Цогт цэций сумын ЦДАШ-ын уртыг зураг, төсөл дээр 12.4 км, ЭХСХТ-ийн техникийн нөхцөл дээр 18 км-ээр, Хулд-Цогт Овоогийн ЦДАШ-ын ажилд шаардагдах тулгуурын тоог зурагт 399, зургийн паспортад 841-ээр зөрүүтэй заасан, Тэлмэн-Тосонцэнгэл, Түдэвтэй-Цэцэн-Уулын ЦДАШ-ын ажлын нэгдсэн зураг ба материалын түүврийн төмөр болон бетон хийцийн хэмжээ зөрүүтэй, Өлгий-Цагаан нуурын ЦДАШ-ын ажлын зурагт 8 км мөнх цэвдэгтэй гэж тусгасан боловч 35 км газар 2 м-ээс мөнх цэвдэг гарсан, Баруунбаян Улаан-Баянлиг сумын 35 квт-ын дэд станцыг өөр объектын зураг төслөөр барьж эхлүүлсэн байна;

- Тайширын УЦС-Улиастайн 110 кВ-ын ЦДАШ болон Тайшир-Алтайн 35 кВ-ын ЦДАШ, дэд станцад зайлшгүй хийх шаардлагатай ажил зураг төсөвт тусгагдаагүйгээс Тайширын УЦС-ын ус хуримтлуулах талбайд орсон 110 кВ-ын ЦДАШ-ын анкер болон завсрын тулгууруудыг буцаан сугалж, өөр газарт шинээр барих, 278-286 дугаар тулгууруудын хоорондох шугамыг буулган трассыг өөрчилж шинээр барих зэрэгт нэмж 130.2 сая төгрөг зарцуулахаар ТЭХ-ний сайдын 2008 оны 109 дүгээр тушаалаар шийдвэрлэсэн;
- ЦДАШ-ын Хөвсгөл, Баянхонгор аймагт баригдаж буй Мөрөн-Алаг Эрдэнэ-Хатгал-Чандмань Өндөр, Баянхонгор-Бөмбөгөр-Бууцагаан зэрэг 6 шугамын урт 100 км-ээс дээш гарч багтаамжийн гүйдэл зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрчээ. Гэтэл зураг төсөлд нум унтраах реактор суурилуулах асуудлыг цахилгаан байгууламжийн дүрмийн 1.2.8-ын дагуу шийдэж өгөөгүй байна.


1.12 Цаашид түлш, эрчим хүчний салбарын норм, норматив, стандарт, үнэлгээг шинэчлэн боловсруулан мөрдөж, зураг төсөв, техникийн нөхцөл, үндэслэлийг батлагдсаны дараа хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаж байх шаардлагатай байна.

1.13 Үйлдвэр худалдааны сайд (хуучин нэрээр)-ын 2006 оны 46 дугаар тушаалаар 11 аймаг, хилийн боомтод газрын тосны бүтээгдэхүүнийг хүлээн авах болон түгээх үеийн чанарын хяналтын шинжилгээ хийх хүчин чадал бүхий лабораторийг байгуулахаар шийдвэрлэсний дагуу эдгээр лабораторид ашиглагдах тавилга, тоног төхөөрөмж, урвалж бодисыг 2008 онд төсвийн хөрөнгө оруулалтаар худалдан авсан боловч 2009 онд 4 аймгийн төлөөлөгчийн газрыг татан буулгасан тул нийт 160,0 орчим сая төгрөгийн лабораторийн тавилга, шилэн эдлэл, химийн бодис одоогоор агуулахад ашиглагдахгүй хадгалагдаж байна.

1.14 Энэ нь хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг боловсронгуй болгох, Засгийн газрын болон салбарын дунд, урт хугацааны хөтөлбөр, зорилтод тусгагдсан төсөл арга хэмжээг ач холбогдол, хүлээгдэж буй үр дүнгээр нь эрэмбэлэн санхүүжүүлэхээр төлөвлөх зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

#### **Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам:**

1.15 ЗТБХБ-ын салбарын 2008 оны хөрөнгө оруулалтын батлагдсан төлөвлөгөөг бүтцээр харуулбал: (сая төгрөгөөр)



1.16 Графикаас үзвэл тус салбарт улсын төсөв болон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр нийт 144,782.4 сая төгрөг, үүнээс авто зам, гүүрийн шинэчлэл, засварт 58.0 хувь, нисэхийн барилга байгууламж, тоноглолд 13.7 хувь, барилга, хот байгуулалтад 28.3 хувийг зарцуулахаар төлөвлөжээ.

#### **Эх үүсвэр нь шийдэгдээгүй шугамд их хэмжээний хөрөнгө зарцуулжээ**

#### **Эрдэс баялаг, эрчим хүчний яам:**

1.17 ТБУСТХ-д зааснаар байгууллагын вйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө нь тухайн байгууллагын төсөв боловсруулах үндэслэл болох бөгөөд ирэх 3 жилд эрхлэх вйл ажиллагаатай холбогдсон хэтийн зорилтуудыг тусгах ёстой.

1.18 Дээрх зорилтод нийцүүлэн Эрдэс баялаг, эрчим хүчний салбарт хэрэгжүүлж байгаа Эрчим хүчний нэгдсэн систем хөтөлбөр, Сэргээгдэх эрчим хүчний болон “100000 нарны гэр” үндэсний хөтөлбөр, Сум суурин газрын дулаан хангамжийн хөтөлбөр, Шингэрүүлсэн шатдаг хий хөтөлбөр, Эрчим хүчний тогтвортой хөгжлийн стратеги төлөвлөгөөтэй уялдуулан хөрөнгө оруулалтыг ач холбогдол, гарах үр дүнгээр нь эрэмбэлж, тухайн оны төсөвт тусгуулах саналыг боловсруулж байна.

1.19 Гэвч цахилгаан дамжуулах шугам, дэд станцыг тэдгээрийн эх үүсвэрийн нөөц, объектын техник эдийн засгийн үндэслэлийг харгалзахгүй, эсвэл тодорхой тооцоололгүйгээр хөрөнгө оруулалтыг төлөвлөн гүйцэтгэсэн байна.

1.20 “Гэрээ шууд байгуулан хэрэгжүүлэх эрчим хүчний төсөл, арга хэмжээний тухай” Засгийн газрын 2007 оны 50, 220 дугаар тогтоол, ТЭХ-ний сайдын 2007 оны 25, 73 дугаар тушаалын дагуу Улсын төсвийн болон МУХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ЭХ-ний 69 төсөл, арга хэмжээ, зураг төслийг шууд гэрээгээр гүйцэтгүүлэхээр 36 компанийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулжээ.

1.21 Дээрх тогтоол, тушаалаар:

- Завхан аймгийн Арцсуурь боомт-Тэс сумын 10 кВ-ын 36 км ЦДАШ, дэд станц барих 400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Илч хангай” ХХК гүйцэтгэн 2008 онд дуусч, санхүүжилтийн 97% хийгдсэн боловч ОХУ-аас холболт хийх зөвшөөрөл өгөөгүй шалтгаанаар ашиглах боломжгүй болжээ. Эх үүсвэрт холбогдох боломжгүй шугамыг төлөвлөгөөнд тусгасан талаар зохих байгууллагуудад БУА эхлэхийн өмнө болон дараа хандаж байсан боловч захиалагч ТЭХЯ (хуучин нэрээр) ажлыг эхлүүлснээр 388.0 сая төгрөгийн хөрөнгийг үргүй зарцуулж, одоо өөр эх үүсвэрээс холбох 3 хувилбар, горимын тооцоолол хийж байна.
- Ховд аймгийн Булган сумыг БНХАУ-ын Такашикен боомтоор дамжуулан ЦДАШ-аар холбож эрчим хүчээр хангах 35 кВ-ын шугам, дэд станц, эх үүсвэрийн байршил тодорхойгүй, дээрхийн адил нөхцөл үүссэн тул 2008 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд туссан БУА-ын тендер зарлагдаагүй түр хугацаагаар хойшилсон;
- МУЗГ-ын 2007 оны “Гэрээ шууд байгуулан хэрэгжүүлэх эрчим хүчний төсөл, арга хэмжээний тухай” 220 дугаар тогтоолыг үндэслэн ТЭХ-ний сайдын 73 дугаар тушаалаар батлагдсан төсөл арга хэмжээний жагсаалтад шууд гэрээ байгуулан хэрэгжүүлэхээр уг тогтоолд заагдаагүй Манхан-Мөст, Түдэвтэй-Асгат-Баянтэс, БНХАУ-ын хил-Сүмбэрийн зэрэг 1,799.0 сая төгрөгийн өртөг бүхий ЦДАШ-ын 6 ажлыг 2007 онд нэмсэн байна.

1.22 Тайширын УЦС-ын төлөвлөгдсөн хүчин чадлаар 8 сум, суурин газрыг эрчим хүчээр хангахаар тооцоолжээ. Гэтэл 2007-2008 онд тус станцаас хүчдэлийн эх үүсвэр өгөхөөр Завхан, Говь-Алтай аймгийн нийт 26 суманд ЦДАШ, дэд станц барьж байгуулахад улсын төсвөөс 36,700.0 сая төгрөг зарцуулсан боловч УЦС бүрэн хүчин чадлаараа ажиллаагүй байна.

1.23 Ийнхүү хөрөнгө оруулалтаар барих объектыг зайлшгүй шаардлага, хэрэгцээ, эх үүсвэр болон ТЭЗҮ, зураг төсвийг үндэслэн төлөвлөж гүйцэтгээгүйгээс улсын төсөв, МУХС-гаас зарцуулсан их хэмжээний хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна.

**Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам:**

1.24 2002 онд батлагдсан Монгол Улсын барилгын салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд 2001-2010 онд цемент, төмөр бетон хийцийн үйлдвэр барьж



дуусгахад 1,504.3 сая төгрөг, үйлдвэрүүдэд хэсэгчилсэн болон бүрэн шинэчлэл өөрчлөлт хийхэд 21,261.4 сая төгрөг, барилгын үйлдвэрүүдийг шинээр барихад 36,141.7 сая төгрөг, нийт 58,907.4 сая төгрөг зарцуулахаар төлөвлөжээ.


1.25 Дээрх зорилтуудаас 2008 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгалгүйгээр үр өгөөж багатай олон жижиг ажлуудад хөрөнгийг тарамдуулан зарцуулсан байна. Тухайлбал, 2008 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр инженерийн болон цэвэр бохир усны шугам сүлжээ шинээр барих, засварлахад 28,458.3 сая төгрөг, Архангай, Дархан-Уул аймгийн төвийн үерийн далангийн барилгад 961.4 сая төгрөг, 6 аймагт халуун усны барилга барих, 119 суманд ус зөөлрүүлэх тоног төхөөрөмж суурилуулахад 669.4 сая төгрөг, нийтийн зориулалттай байрны цахилгаан шатны шинэчлэл, дээвэр засвар, гудамж талбайн тохижилтод 1,447.0 сая төгрөг, дутуу баригдсан байруудыг дуусгахад 701.7 сая төгрөг зарцуулахаар төлөвлөн гүйцэтгэжээ.

1.26 Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтаар тухайн жилд гүйцэтгэх ажлыг төлөвлөхдөө хэтийн зорилтод тусгасан барилгын үйлдвэрлэл хөгжүүлэх бодлогыг баримтлаагүй байна.

### **Хөрөнгө оруулалтын зарим арга хэмжээг МУХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх шаардлага үүссэн байна**

#### **Эрдэс баялаг, эрчим хүчний яам:**

1.27 УИХ-аас 2008 оны төсвийн тухай хуульд 2008 оны 10 дугаар сард өөрчлөлт, тодотгол хийхдээ анх батлагдсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТЭХ-ний салбарт 9,606.2 сая төгрөгөөр, эрдэс баялгийн салбарт 1,000.0 сая төгрөгөөр тус тус бууруулан хөрөнгө оруулалтын төсвийг нийт 79,696.8 сая төгрөгөөр баталжээ. Өөрчлөлтийг графикаар харуулав. (сая төгрөгөөр)



1.28 Батлагдсан тодотголын 26.1 хувийг өмнөх оноос шилжин ирсэн эрчим хүчний БУА-г, 73.9 хувийг шинээр эхлэх ажлыг санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүний дотор он дамжин хэрэгжиж байгаа 2,198.4 сая төгрөгийн ажлыг анхны төлөвлөгөөнд тусгалгүйгээр тодотгосон төсөвт оруулж баталсан боловч санхүүжүүлээгүй байгаа нь энэхүү хөрөнгийг төсвийн тодотголд оруулах

шаардлагагүй байсныг харуулж байна.

1.29 Төсвийн тодотголыг 2008 оны 4 дүгээр улиралд хийсэн нь гүйцэтгэгчийг сонгож, зарим төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхэд хугацаа их алдаж, оройтуулах нөхцөлийг бүрдүүлжээ. Тухайлбал, УБ хотын “Өмнөд” дэд станцад гарсан ослын мөрөөр авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2008 оны 107 дугаар тогтоолоор дэд станцыг шинэчлэх, хэрэглэгчдийг цахилгаан эрчим хүчээр хэвийн хангахад шаардагдах хөрөнгийг 3,550.0 сая төгрөгөөр баталж, төсвийн багцдаа зохицуулалт хийх замаар шийдвэрлэхийг ТЭХ-ний сайд, Сангийн сайд нарт даалгасан байна.

1.30 Үүний дагуу “Өмнөд” 110/10/6 кВТ-ын дэд станцыг шинэчлэх ажлын гүйцэтгэгчийг 2 багц болгон шууд гэрээ байгуулжээ. 1 дүгээр багцын гүйцэтгэгч Хан хув ХХК 2008 оны 5 дугаар сарын 26-наас 7 дугаар сарын 8-ны хооронд ажлыг гүйцэтгэх гэрээтэй байсан боловч тухайн төсөл, арга хэмжээний хөрөнгийн эх үүсвэр шийдэгдээгүй, захиалагч урьдчилгаа төлбөрийг олгоогүй, нийлүүлэгч санхүүгийн чадваргүй зэргээс шалтгаалан хугацаанд нь хийгээгүй байна.



1.31 Захиалагч ЭБЭХЯ-наас дээрх ажлын 2 дугаар багцад шалгарсан Илч хангай ХХК-д олгох 800.0 сая төгрөг, Хайлааст гэр хорооллын 110/35/10 дэд өртөөний ажлын гүйцэтгэгч Автоматика ХХК-д олгох 869.6 сая төгрөгийг Анод банкин дахь харилцах дансанд 2008 оны 11 дүгээр сард шилжүүлсэн боловч өнөөг хүртэл тус банкинд саатаж байна.

**Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам:**

1.32 2008 онд ЗТБХБ-ын салбарт улсын төсвөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын хэмжээг 41,526.5 сая төгрөгөөр бууруулсан боловч эх үүсвэр дутагдсантай холбогдуулан МУХС-аас санхүүжүүлэх хэмжээг 14,891.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн тодотголыг хийжээ.

1.33 ЗТБХБ-ын салбарт гүйцэтгэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсвийн тодотголыг хүснэгтээр үзүүлбэл: (сая төгрөгөөр)

/Хүснэгт №2/

Үзүүлэлт	2008 оны төсвийн хуулиар			Төсвийн тодотголоор		
	Улсын төсөв	МУХС	Нийт дүн	Улсын төсөв	МУХС	Нийт дүн
ЗТБХБЯ-ны төлөвлөсөн санал	96 174,5	95 814,0	191 988,5	68 094,4	73 627,8	141 722,2
СЯ-наас оруулсан санал	78 148,7	47 323,8	125 472,5	52 774,9	58 160,8	110 935,7
УИХ-аар батлагдсан	80 102,4	64 810,0	144 912,4	38 575,9	79 701,5	118 277,4

1.34 2008 оны төсвийн тодотголоор ЗТБХБЯ, СЯ-наас боловсруулсан хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөлд УИХ-аас шинээр нэмж, барилгын хөрөнгө оруулалтын 21 төсөл арга хэмжээнд 1,957.0 сая төгрөг, их засварын 7 ажилд 370.0 сая төгрөг, ус цэвэршүүлэх, зөөлрүүлэх тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтад 50.4 сая төгрөг, Тээлийн голын төмөр бетон гүүр барихад 246.2 сая төгрөг, Говь-Алтай аймгийн нисэх буудлын хатуу хучилттай зурвас, үерийн далан барихад 1,000.0 сая төгрөг, Сэлэнгэ мөрөн дээгүүр хөвөгч гүүр барихад 54.0 сая төгрөгийг зарцуулахаар шийдвэрлэн баталжээ.

## Бүлэг 2

### Худалдан авах ажиллагаанд хуулийг жигд баримтлаагүй байна

#### Тендерийн хуулийг бүрэн хэрэгжүүлээгүй байна

##### *Эрдэс баялаг, эрчим хүчний яам:*

2.1 ТЭХ-ний салбарын 2008 оны хөрөнгө оруулалтын төсөвт тусгагдсан шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг Сангийн яаманд хуульд заасан хугацаанд хүргүүлсэн байна.

2.2 2008 онд улсын төсвийн болон МУХС-ийн хөрөнгөөр 48 сум, суурин газрыг ЦЭХ-ээр хангахаар төлөвлөсөн боловч гүйцэтгэгчийг шалгаруулах хугацаа оройтсоноос 7 төсөл арга хэмжээний тендер зарлагдаагүй байна.

2.3 Үлдэх 41 тендерийн 32-ыг нээлттэй, 3-ыг хязгаарлагдмал, 6-г шууд гэрээ байгуулах аргаар зохион байгуулжээ. Үүнээс 3 тендер үнэлгээний шатанд, санал ирээгүйгээс 1, зураг төсөл бэлэн болоогүйгээс 1 тендер тус тус хүчингүй болж, 36 тендер гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулжээ.

2.4 ТЭХ-ний сайдын тушаалаар 12 төсөл арга хэмжээний БУА-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах эрхийг ЭХСХТ болон Уул уурхайн аврах албанд шилжүүлсэн байна.

2.5 2008 онд зарлагдсан нээлттэй болон хязгаарлагдмал аргаар гүйцэтгэгчийг сонгосон 53 тендерийн үнэлгээний хорооны 68 гишүүний 13 нь 10-20 тендерт үнэлгээний хорооны гишүүнээр ажиллажээ.

2.6 Тендерийн хуулийн 45.2.2-д заасны дагуу 500.0 саяас дээш өртөг бүхий ажлын хувьд яам захиалагч болох, захиалагч нь үнэлгээний хороог зохион байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавих, үнэлгээний хорооны зөвлөмжид үндэслэн гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах байтал ТЭХЯ дээрх босго үнээс давсан тендерүүдэд гэрээ байгуулах эрх олгох зөвлөмжийг ЭХСХТ-ийн даргад хүргүүлж байжээ.

2.7 Сангийн сайдын 2006 оны 418 дугаар тушаалаар баталсан “Ажлын гүйцэтгэгч сонгох тендерийн жишиг баримт бичиг”-ийг гүйцэтгэгчтэй байгуулах гэрээ бүрт жигд баримтлаагүй, хуулийн холбогдох заалтыг зөрчсөн байна. Тухайлбал, 1,000.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй Нүүрсний хими технологийн туршилт судалгааны лабораторийн БУА-ын захиалагчийн эрхийг ЭХСХТ-д шилжүүлснээс гадна захиалагч тендерт зураг төсвийн даалгаврыг оруулан зарласан, гүйцэтгэгч “Хөхий Хан” ХХК-тай байгуулсан гэрээнд барьцааны хэмжээг үнийн дүнгийн 0,5 хувь байхаар заасан нь тендерийн хуулийн холбогдох заалтын доод хэмжээнээс 10 дахин бага байна. Үүний улмаас гүйцэтгэгч тендерийн шаардлагад нийцээгүй зураг зохион батлуулж, БУА-ыг гэрээнд заасны дагуу бүрэн хийгээгүй боловч 2009 оны 2 дугаар сард улсын комисс хүлээн авчээ.

### **Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам:**

2.8 ЗТБХБ-ын салбарт улсын төсвийн хөрөнгөөр нийт 18.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 38 төсөл, арга хэмжээг нээлттэй тендер зарлаж, санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 33 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээг байгуулсан ба үүнээс 19 ажил нь ондоо багтан бүрэн хэрэгжиж, 13 ажил он дамжин хийгдэж байна. Үлдэж буй ажлуудын хувьд тендер хүчингүй болсон 4, ажлын зургийг боловсруулж байгаа 1 байна.

2.9 ЗТБХБЯ-ны 2008 оны худалдан авалтыг хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт №3/				
№	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл	Тендерийн тоо	Төсөвт өртөг. /сая.төг/	Дүнд эзлэх хувь
1	Авто замын сүлжээний засвар, өргөтгөл, шинэчлэл	14	6 658,5	4,2
2	Зураг төсөл, ТЭЗҮ боловсруулах	12	1 225,0	0,8
3	Авто зам	12	107 011,0	66,8
4	Гүүр	6	7 985,9	5,0
5	Тээвэр	3	380,0	0,2
6	ИНЕГ	6	17 700,0	11,1
7	Барилга	29	19 173,7	12,0
<b>Нийт дүн</b>		<b>82</b>	<b>160 134,1</b>	<b>100,0</b>
Үүнээс хүчингүй болсон тендер		8	32 550,0	20,3

2.10 МУХС-ийн хөрөнгөөр нийт 38.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр төлөвлөснөөс нээлттэй тендер шалгаруулж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан 8, тендер зарласан боловч тендер оролцогчдын ирүүлсэн үнийн санал батлагдсан төсвөөс хэт өндөр байснаас хүчингүй болсон 3 төсөл, арга хэмжээ байна.

2.11 Замын сангийн хөрөнгөөр авч хэрэгжүүлэх нийт 8 төсөл, арга хэмжээнээс 5 нь бүрэн хэрэгжиж дууссан, 1 ажил нь хийгдэж байгаа, 2 тендер нь ажлын зураггүй болон тоо хэмжээг дахин нягтлан шалгах шаардлагын улмаас хүчингүй болсон байна.

2.12 Барилгын салбарт 2008 онд Улсын төсөв, МУХС-ийн хөрөнгөөр нийт 58 төсөл арга хэмжээг авч хэрэгжүүлэхээс тендерийн хуулийн 0.5 тэрбум төгрөгөөс доош төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээг орон нутагт эрхийг шилжүүлнэ гэсэн заалтыг баримтлан 2.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 26 төсөл, арга хэмжээг орон нутагт шилжүүлж, төсвийн тодотголоор 6 төсөл арга хэмжээний 9.8 тэрбум төгрөг хасагдан, нийт хэрэгжүүлэх 26 төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 33.2 тэрбум төгрөг болсон байна.

2.13 Он дамжин хэрэгжиж байгаа болон 2008 онд шинээр эхэлсэн нийт 26 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, улсын комисст хүлээлгэн өгсөн байна.

2.14 Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх 6 төсөл, арга хэмжээний 4 нь гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан хийгдэж байгаа, 1 нь үнэлгээний шатандаа, 1-ийнх нь хувьд шүүхэд гомдол гарсан байна.

2.15 ИНЕГ-ын өөрийн хөрөнгөөр нийт 93 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд тендерийн хуулийн дагуу 81 ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, ажлыг эхлүүлээд байгаагийн 62 нь бүрэн хэрэгжиж дууссан, 19 ажил хэрэгжилтийн шатандаа, 12 ажил мэргэжлийн байгууллагын дүгнэлт

шаардлагатай, батлагдсан төсвөөр хийх боломжгүй, төсвийн тодотгол хийх зэрэг шалтгаанаар хэрэгжээгүй байна.

2.16 ЗТБХБЯ-ны 2008 оны худалдан авах үйл ажиллагааны хэрэгжилт 88 хувьтай байна.

### **Зарим ажлын гүйцэтгэчийг зохих журмын дагуу шалгаруулаагүй байна**

#### **Эрдэс баялаг, эрчим хүчний яам:**

2.17 ЭХ-ний салбарт өмнөх гэрээт ажлыг гүйцэтгэх хугацаа хэтэрсэн, улсын комисст хүлээлгэн өгөөгүй байхад зарим компаниудтай дахин гэрээ байгуулсан байна. Тухайлбал, Баян констракшн ХХК-тай 8.4 тэрбум төгрөгийн 7 гэрээ, Очир төв ХХК-тай 7.6 тэрбум төгрөгийн 9 гэрээг дахин байгуулжээ.

2.18 2008 онд шинээр болон урьд оноос шилжиж хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын гол гүйцэтгэгчдийг хүснэгтээр үзүүлбэл:

/Хүснэгт №4/

№	Гүйцэтгэгчээр шалгарсан компаний нэр	Тендерт гүйцэтгэгчээр шалгарсан ажлын тоо				Төсөвт өртөг (сая төгрөг)	Ажил гүйцэтгэсэн байдал
		2005	2006	2007	2008		
1	Алтай трест	1	1	1	1	10504.4	Дуусаагүй БУА-
2	Нью прогресс		1	4	2	11916.7	Дуусаагүй БУА-
3	Баян констракшн		5			23673.7	Дуусаагүй БУА-
4	Илч хангай		1	5	3	14396.4	Дуусаагүй БУА-
5	Мегаватт		1	2		10742.0	Дуусаагүй БУА-
6	Хасу эрчим				4	2835.0	Дуусаагүй БУА-
7	ЭХБУТ			4		9978.4	Дуусаагүй БУА-

2.19 Дээрх 7 компани 2008 онд хийгдсэн ЦДАШ-ын БУА-ын 50.1 хувийг буюу 22.1 тэрбум төгрөгийн ажлыг гүйцэтгэжээ.

2.20 Эдгээр компанийн гүйцэтгэсэн ажлын чанар, гэрээний хугацаатай холбогдон гарсан дутагдлууд нь тендер шалгаруулах явцад тэдгээрийн ажиллах хүчний нөөц, санхүүгийн хүчин чадлыг буруу дүгнэснээс шалтгаалсан байна. Тухайлбал, 2007 онд Хэнтий аймгийн Баян-Адрага Норовлин сумын 880.0 сая төгрөгийн, Баян-Адрага Дадал сумын 840.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 15 квт-ын ЦДАШ, дэд станцын БУА-ын гүйцэтгэгчээр шалгарсан Очир төв ХХК Тендерийн хуулийн 41.2-д “Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно” гэж заасныг зөрчин Сан ХХК-иар ЦДАШ-ын Баян-Адрага-Норовлин сумын ажлыг 762,0 сая, Баян-Адрага-Дадал сумын ажлыг 736,0 сая төгрөгөөр хийлгэсэн байна.

2.21 2008 онд эрчим хүчний салбарт хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэгчийг сонгох 36 тендерийг зарлаж, дүгнэсэн ба оролцогчдоос 12 тендерийн үйл ажиллагаатай холбогдсон гомдол ирүүлснийг СЯ болон ТЭХЯ хянаж, Баянхонгор аймгийн Бөмбөгөр-Бууцагаан сумын 35 кВ-ын ЦДАШ-ын тендерт Сан ХХК-г шалгаруулсан шийдвэрийг хүчингүй болгон, Илч Хангай ХХК-ийг шалгаруулжээ.

2.22 Тендерийн хуулийн 49.5-д заасны дагуу Эрдэс баялаг, эрчим хүчний, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын салбарын 2008 онд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг хугацаанд нь гаргаж, Сангийн яаманд хүргүүлжээ.

2.23 Тендерийн хуулийн 49.1-д “Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж, архивын нэгж болгоно”, Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.25-д “Тухайн төслийн тендерийн үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, зөвлөмж, ажил гүйцэтгэх гэрээ ... холбогдох бусад баримтыг зохих журмын дагуу архивлана” гэж заажээ.

2.24 Гэвч ЗТБХБЯ, ЭБЭХЯ болон ЭХСХТ төсөл, арга хэмжээ бүрээр зураг, төсөв, ТЭЗҮ, тендерт оролцогчдоос ирүүлсэн баримт материал, үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, тайлан, шалгаруулалт, гэрээ, холбогдох бусад баримт бичгийг архивлах ажлыг хуулийн дагуу хийгээгүй, баримтын эмх цэгц хангалтгүй байна.

2.25 СЯ-наас худалдан авах үйл ажиллагаанд үнэлгээ хийж, “Захиалагч нь 2008 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг ирүүлэхдээ Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуульд тусгагдсан төсөл, арга хэмжээ бүрээр мэдээллийг бүрэн гаргаж ирүүлээгүй, цахим хуудаст тендерийн урилга, үр дүнг нийтлээгүй” зэрэг зөрчил гаргасныг дурдаад, худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг нийт 100 оноо бүхий шалгуур үзүүлэлтээр дүгнэхэд ЭБЭХЯ 71, ЗТБХБЯ 65 оноо тус тус авсан байна.

## Бүлэг 3

### Хөрөнгө оруулалтын гүйцэтгэл хангалтгүй байна

Гэрээ байгуулах эрх зүйн орчинг боловсронгуй болгох шаардлагатай байна

**Эрдэс баялаг, эрчим хүчний яам:**

3.1 УИХ-аас тендерийн хуулийн 34.1.6, 34.4-т 2007 оны 2 дугаар сард оруулсан нэмэлт өөрчлөлтийг үндэслэн гаргасан “Гэрээ шууд байгуулан хэрэгжүүлэх эрчим хүчний төсөл, арга хэмжээний тухай” ЗГ-ын 2007 оны 50, 220 дугаар тогтоол, ТЭХ-ний сайдын 2007 оны 25, 73 дугаар тушаалын дагуу Улсын төсвийн болон МУХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх ЭХ-ний барилга угсралт, зураг төслийн 69 ажлыг түлхүүр гардуулах гэрээний нөхцөлөөр, шууд гэрээгээр гүйцэтгүүлэхээр 36 компанитай гэрээ байгуулжээ.

3.2 Захиалагч байгууллагаас өгсөн техникийн нөхцөл, зургийн даалгавар, газар орны онцлогийг бодитой тусгасан ажлын зураг, төсөвгүй байхад 2007 онд шууд гэрээ байгуулан ажил эхлүүлснээс гэрээний дагуу санхүүжилт авсан ЦДАШ-ын урт нь ажлын зурагт тусгагдсанаас ихээхэн зөрүүтэй гарч, 41 объектод 4,947.3 сая төгрөгийн санхүүжилтийг илүү, 1128.0 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгожээ. (Хавсралт 1-ээс үзнэ үү)

3.3 Шугамын уртыг дутуу тооцсон 14 объектын нэмэлт санхүүжилтэд 1,128.0 сая төгрөгийг гүйцэтгэгч компаниудад буцаан олгохоор 2008 оны төсөвт төлөвлөж, батлуулсан боловч илүү олгосон 4,947.3 сая төгрөгийг хураан барагдуулж, улсыг хохиролгүй болгох ажил одоо болтол хийгдээгүй байна.

3.4 Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын лабораторийн тоног төхөөрөмжийг худалдан авах 7 багц бүхий тендерийн 1 дүгээр багцын гүйцэтгэгчээр Эм Пи Ай ХХК-ийг шалгаруулан 1,887.3 сая төгрөгийн гэрээ байгуулж, банкны баталгааг үндэслэн урьдчилгаа 660.7 сая төгрөгийг 2008 оны 12 дугаар сард шилжүүлжээ. Гэрээнд 2 дахь шатны санхүүжилт болох үнийн дүнгийн 50 хувийг бараа ачигдахад бэлэн болсон тухай баримтыг үндэслэн төлөхөөр заасан боловч 2009 оны батлагдсан төсвөөр тухайн төсөл арга хэмжээний санхүүжилтээс 500.0 сая төгрөг хасагдсан байна. Гүйцэтгэгч ОХУ, Герман Улсаас барааг авах гэрээний дагуу эхний ээлжийн барааг гааль дээр хүлээн авсан тухай захиалагчид мэдэгджээ. Иймээс гэрээний зохицуулалтыг хийж, батлагдсан төсөвт багтаан худалдан авалтыг хийх талаар гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай болжээ.

**Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам:**

3.5 Хатуу хучилттай авто замын Өндөрхаан-Сүмбэр, Мөрөн-Хатгалын чиглэлийн тендерийг 2008 оны 2, 6 дугаар сард зарлаж, гэрээ байгуулах эрхийг 9 дүгээр сарын 22-нд олгосон зэрэг 10 гаруй тендерийн урилгыг худалдан авах ажиллагааны журам зөрчин 3-6 дугаар сарын хооронд хэвлэлд нийтэлж, ажил эхлүүлэх гэрээг гүйцэтгэгчидтэй 2008 оны сүүлийн хагас жилд байгуулжээ.

3.6 Гэрээний үүргээ биелүүлээгүйн улмаас явцын дунд гэрээ цуцлах байдал хэд

хэдэн удаа гарчээ. Тухайлбал: “АСБИ” ХХК, “Аваргас” ХХК-иудтай байгуулсан гэрээг 2008 онд цуцласан байна.

3.7 ЗБА-ын гүйцэтгэгчид хөрөнгө оруулалтад зарцуулах хөрөнгийн буюу гэрээний үнийн дүнгийн 37 хүртэл хувьтай тэнцэх хөрөнгийг тендерийн, гүйцэтгэлийн, урьдчилгаа төлбөрийн баталгааг гаргуулахад зарцуулан банкинд байршуулж байгаа нь гүйцэтгэгч компаниудад санхүүгийн дарамт болж байна.

### Гэрээний гүйцэтгэлийг дүгнэх ажил үр нөлөөгүй болжээ


#### **Эрдэс баялаг, эрчим хүчний яам:**

3.8 2008 онд ЭХ-ний салбарт урьд оноос үргэлжлэн хийгдэж буй 23, шинээр хийгдэж буй 19 хөрөнгө оруулалтын ажлын гэрээг дүгнэж, нийт 679.8 сая төгрөгийн алданги тооцсон боловч гүйцэтгэгчдээр хүлээн зөвшөөрүүлж барагдуулах ажил хийгдээгүй байна. Түлхүүр гардуулах нөхцөлөөр байгуулсан шууд гэрээний захиалагчаар ЭХСХТ ажилласан боловч шийдвэрийг захиалагч бус ТЭХЯ-аар эцэслэн гаргуулахаар гэрээг дүгнэсэн нь гэрээний заалттай зөрчилдөж байна. Үүнээс шалтгаалан хөрөнгө оруулалтын ажлыг дуусгах хугацаа хожимдуулсан гүйцэтгэгчдэд ногдуулсан алдангийг барагдуулж чадаагүй байна.

3.9 ТЭХ-ний салбарт 2008 онд хийхээр төлөвлөсөн нийт хөрөнгө оруулалтын ажлын 81.5 хувийг буюу 64,921.6 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэсэн байна.

3.10 Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг графикаар харуулбал: (хувиар)

3.11 Графикаас харахад 32 сумын төвийг ЭХ-ний төвлөрсөн системд холбосон 2361 км ЦДШ, дэд станц барихад 68.2 хувийг, ДЦС-ын засвар, шинэчлэлт, дулааны шугамын их засварт 12.6 хувийг, нар, салхины эрчим хүчний эх үүсвэрээр 19.0 мянган өрхийг хангахад 10.6 хувийг, түлшний болон эрдэс баялгийн салбарт 6.9 хувийг, ЭХ-ний төсөл, арга хэмжээний хайгуул, судалгаа зураг, төсөв боловсруулахад 1.7 хувийг тус тус зарцуулжээ.



3.12 Урьд оноос шилжиж ирсэн 19, шинээр хийхээр төлөвлөсөн 9 ЦДАШ-ын БУА дууссан боловч хүчдэлийн эх үүсвэр болох Тайширын УЦС бүрэн хэмжээгээр ашиглалтад ороогүйгээс 36,700.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй баригдсан шугамыг хүчдэлд залгах боломжгүй, ашиглаагүй байна.

3.13 Үүнээс гадна шилжиж ирсэн ЦДАШ-ын БУА-ын 26-д нь улсын комисс, 10-д нь ажлын болон техникийн комисс, шинээр төлөвлөгдөн хийгдсэн ажлын 17-д нь улсын комисс, 3-д нь ажлын комисс ажиллажээ.

3.14 2008 онд хийхээр төлөвлөсөн ЦДАШ-ын барилга угсралтын 109 ажлаас дууссан 84, дуусаагүй 10, эхлээгүй 10, төлөвлөгөө ёсоор дараа онд үргэлжлэн хийгдэх 5 байна.

3.15 БНХАУ-ын Зүүн хатавч боомт-Эрдэнэцагаан сумын ЦДАШ, дэд станцын БУА дууссан боловч хүчдэлийн эх үүсвэргүй, ашиглагдаагүй байна.



3.16 МУХС-ийн 2008 оны төсвийн тухай хуулиар 5.0 тэрбум төгрөгийг сумдын 0.4 кВ-ын ЦДАШ-ыг шинэчлэхэд зарцуулахаар төлөвлөсний дагуу ТЭХС-ын 2008 оны 38 дугаар тушаалаар уг ажилд 17 аймгийн 123 сумыг хамруулах жагсаалт болон зарцуулах хөрөнгийн хэмжээг баталж, гүйцэтгэгч 42 компанийг харьцуулалтын аргаар шалгаруулж, гэрээ байгуулсан байна.


3.17 Гүйцэтгэгчид гэрээт ажлын 61 хувь буюу 75 гэрээний хугацааг 5-175 хоногоор хоцроосон тул алданги 15.2 сая төгрөгийг эцсийн санхүүжилтээс суутган тооцож, төлөвлөгдсөн хөрөнгөөс 55,5 сая төгрөг үлдсэн байна.

3.18 Зарим гүйцэтгэгчдээр 3-7 сумын ЦДАШ-ын ажлыг зэрэг гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн нь гэрээний хугацаа хэтрэх, ажлын гүйцэтгэл, чанарт сөргөөр нөлөөлж, ашиглагч байгууллага, иргэдээс гомдол гарах нөхцөл болжээ.

3.19 Гэрээний гүйцэтгэлийг хугацаа хэтрэлтээр нь үзүүлбэл:

					/Хүснэгт №5/
	Гүйцэтгэгч компани	0.4-ын шугам шинэчлэгдсэн аймаг	Сумдын тоо	Гэрээний хугацаа	Хугацаа хэтэрсэн хоног
1	“Хасу меговатт	Баян-Өлгий	4	5/22-7/15	143
2	“Электромонсеть” ХХК	Баян-Өлгий	3	5/22-6/30	160
3	“Биндэгноров” ХХК	Баянхонгор	4	5/12-6/20	67-88
		Өвөрхангай	3	5/12-6/20	67
4	“Хан хув”	Увс	3	4/24-6/30	
			2	5/12-6/30	
5	“Инженер энерги” ХХК	Ховд	7	5/22-7/15	150
6	“Пи-И-Эс” ХХК	Хөвсгөл	4	5/22-6/30	167
7	“Аркади” ХХК	Дорноговь	5	5/12-6/25	71-85
8	“Багануур энерги” ХХК	Дундговь	4	5/22-6/30	5
			1	5/22-7/31	7
9	“Цагаанхорол” ХХК	Өвөрхангай	4	5/22-7/10	21

3.20 Завхан аймгийн Цагаанчулуут сумын /“Хэмтех” ХХК/ 0.4 кВ-ын ЦДАШ-ын 28,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил хийгдээгүй, Хэнтий аймгийн Норовлин, Цэнхэрмандал /“ДиЭсЭй” ХХК/, Жаргалтхаан / “Баянхаан сүлжээ” ХХК/, Завхан аймгийн Яруу /“Монхас” ХХК/, Алдархаан /“Хэмтех” ХХК/, Дорноговь аймгийн Алтанширээ /“Аркади” ХХК/ сумдын шугамын шинэчлэлийн ажилд зориулалтын бус бетонон хөлтэй тулгуур ашигласан, цахилгаан утсанд залгалт их хийгдсэн, ус чийгнээс хамгаалах тусгаарлалтгүй, зарим тоноглолыг дутуу тавьсан, зурагт заагдсан материалыг өөрчилсөн болон хуучин материал ашигласнаас цахилгааны хэлбэлзэл гарч олон айл өрх, байгууллагын цахилгаан хэрэгсэл шатсан, ЦДАШ-ыг хэт унжилттай хийснээс хүчтэй салхинд хавиралт үүссэн зэрэг ажлын чанар, гүйцэтгэлтэй холбоотой зөрчлүүд гарчээ.



3.21 Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Наран сумдын 0.4 кВ-ын шугамын ажлын гүйцэтгэгч “Матад прогресс” ХХК 49.6 сая төгрөг, “Дорнод интернейшнл” ХХК 45.9 сая төгрөгийн санхүүжилтийг 2008 онд бүрэн авсан боловч өнөөг хүртэл ажил бүрэн хийгдээгүй байхад дууссанаар гүйцэтгэл гарган техникийн болон ажлын комисс ажилласан, ашиглалтад хүлээж авснаар акт баримт хуурамчаар

бүрдүүлсэн байна.

3.22 ДБ-ийн сайд, УМХГ-ын даргын 2003 оны 71/134 дугаар тушаалын 1.3-т

“Барьж дуусаагүй буюу дууссан боловч комисс ажиллаж ашиглалтад оруулаагүй барилга байгууламжийг ашиглахыг хориглоно” гэснийг зөрчсөн дээрх байдал болон зөвхөн 12 дугаар сард нийт сумдын 69,9 хувь буюу 86 сумын ЦДАШ-ын ажлын санхүүжилтийг хийсэн зэрэг нь гэрээ дүгнэх, улсын комисс хүлээн авах ажлын чанарт нөлөөлж байна.

3.23 Нэгэнт банкны баталгаа гаргуулан, санхүүгийн чадвартайгаа нотолж, тендерт шалгаран гэрээгээр үүрэг хүлээсэн атал санхүүжилт оройтсон гэх шалтгаанаар гэрээний хугацааг захиалагч сунгаж байгаа нь ажил хугацаандаа дуусахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3.24 Хөрөнгө оруулалтын ажлын 42 гэрээг дүгнэж 679.8 сая төгрөгийн алданги тооцсон боловч гүйцэтгэгчдээр хүлээн зөвшөөрүүлж барагдуулах ажил хийгдээгүй байна. Эдгээр гэрээний захиалагчаар ЭХСХТ ажилласан атлаа шийдвэрийг ТЭХЯ-аар эцэслэн гаргуулахаар гэрээг дүгнэсэн нь гэрээний заалттай зөрчилдөж байна.

3.25 2007-2008 онд ЭХ-ний төвлөрсөн системээс алслагдсан сумдад УЦС 11, нар салхи хосолсон 6, нарны 3, салхины 5 ЦС-ыг байгуулсан ба МУХС-ийн хөрөнгөөр 342 сум, суурин газрын 40400 малчин өрхийг 50 вт-ын чадалтай цахилгаан үүсгүүрээр хөнгөлөлттэй үнээр хангасан боловч 183 нарны цахилгаан үүсгүүрийн 38.4 сая төгрөгийн авлагатай байна.

3.26 СЭХ-ний эх үүсвэрийг нэмэгдүүлэх ажилд МУХС-аас 2008 онд 12,117.8 сая төгрөгийн хөрөнгө зарцуулахаар төлөвлөсөн боловч Дөргөний УЦС-ын БУА-ын нэмэлт санхүүжилтийн 4,700.0 сая, “100000 нарны гэр хөтөлбөр”-ийн 252.6 сая, Баянхонгор аймгийн Баянцагаан, Дорнод аймгийн Матад сумын нар салхи хосолсон эх үүсвэрийн 254.5 сая төгрөгийн санхүүжилтийг хийгээгүй буюу дутуу санхүүжүүлсэн зэргээс шалтгаалан төлөвлөсөн хөрөнгийн 56.9 хувийг зарцуулсан байна.

3.27 2007 онд улсын төсвийн болон МУХС-ийн хөрөнгө оруулалтаар байгуулсан СЭХ-ний 11 объектоос 6-г 14-16 сараар хугацаа хоцроон ашиглалтад оруулсан ба Баянхонгор аймгийн Баянцагаан, Дорнод аймгийн Матад /”Баянконтракшн” ХХК/, Өмнөговь аймгийн Манлай /”Үүрэг трейд” ХХК/, Говь-Алтай аймгийн Бугат /”Нью пауэр” ХХК/ сумдын объектууд ашиглалтад ороогүй байхад санхүүжилтийн 83.0-99.5 хувийг олгосноос гадна гэрээний хугацаа хэтэрсэнд ноогдуулсан алдангийг суутган тооцоогүй байна.

3.28 Сумдын төвийг цахилгаанаар хангах зорилгоор байгуулсан СЭХ-ний ЦС-уудын ТЭЗҮ боловсруулах, байршил тогтоохдоо хэмжилт, судалгааны ажлыг хангалтгүй хийсэн, ажлын туршлагагүй гүйцэтгэгч компанийг сонгосон, суурилагдсан тоноглолын хүчин чадал дутуу, техникийн тодорхойлолтгүй, захиалагчийн хяналт, ажиллах боловсон хүчний сургалт хангалтгүй, ажлыг дутуу орхиж хүлээлгэж өгөөгүй, эзэмшил тодорхойгүй зэргээс эвдрэл гэмтэл, ашиглалтын зөрчил байнга гарч байна.



3.29 Ховд аймгийн Цэцэг сумаас бусад объектуудын операторын байрны дулаан

хангамж муугаас хураагуурын цэнэг авалт, чанар муудсан, компьютерийн систем тогтвортой ажиллахгүй, салхин турбин, сэнс хугарсан, цэнэг тохируулагч шатсан дутагдал нийтлэг гарч байгаа тул баталгаат хугацаанд гүйцэтгэгчдээр засварлуулах, гэрээний үүргийн биелэлтийг хангуулах шаардлагатай байна.

3.30 Сумдыг СЭХ-ээр хангах ажлын захиалагч СЭХҮТ-ийн дарга Н.Энэбиш гүйцэтгэгч комданиудад 2007 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 176 дугаар албан бичгээр техникийн тодорхойлолт дахь инверторын чадал болон цэнэг хураагуурын багтаамжийг бууруулан мөрдөхийг мэдэгджээ. Үүний дагуу хүчин чадал дутуу тоног төхөөрөмж суурилагдсанаас улсад хохирол учирсан, хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд тавих хяналтыг хангалттай зохион байгуулаагүй тул түүнд хариуцлага тооцох, дутуу нийлүүлэгдсэн хүчин чадлын үнийг гүйцэтгэгчээр буцаан төлүүлэх нь зүйтэй байна.

***Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам:***

3.31 2008 онд хөрөнгө оруулалтаар нийт 670 гаруй км хатуу хучилттай авто зам, 860 гаруй уртааш метр төмөр бетон болон модон гүүрийн ажил хийхээр тооцоноос 128.6 км хатуу хучилттай авто зам ашиглалтад оруулсан нь 19,2 хувьтай, 403.5 уртааш метр төмөр бетон болон модон гүүрийг ашиглалтад өгсөн нь 46,9 хувьтай байна.

3.32 Гэрээний гүйцэтгэлийг Тендерийн хууль, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний заалтуудаар дүгнэж байгаа боловч тэдгээрт ажил дүгнэх, хариуцлага болон алданги тооцох ажлыг явц дунд хийх тодорхой заалт байхгүйгээс хариуцлагыг гэрээ цуцлах байдлаар тооцоход гэрээний үнэ өсөх, хугацаа алдах зэрэг эрсдэлүүд бий болж байна.

3.33 Тендерийн хуулийн 34.4-т “Улсын төсвийн хөрөнгөөр барьж байгуулах авто зам, ЭХ-ний төслийн хөрөнгө оруулалтын хэмжээ нь тухайн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг дотоодын нийт ААН-үүдийн хүчин чадалтай тэнцүү буюу түүнээс дээш хэтэрсэн тохиолдолд ЗГ-ын жишиг үнийг үндэслэн, гүйцэтгэгчийг сонгох шаардлагатай гэж үзсэн бол шууд гэрээ байгуулах” гэж заасныг үндэслэн компаниудтай гэрээ байгуулсан боловч үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчидтэй хариуцлага тооцоогүй байна. Тухайлбал,

- Хархорин-Цэцэрлэг чиглэлийн 22.86 км ЗБА-ыг гүйцэтгэхээр шууд гэрээ байгуулсан “Нутгийн зам” ХХК 663.5 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийн, 110.6 сая төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг тус компаний нэрийн өмнөөс Кредит банк гаргасан гэж хуурамч баримт үйлдэж, 657.8 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт авсан боловч ажлаа хийгээгүй байна.
- Мөн чиглэлийн 7.1 км ЗБА-ыг гүйцэтгэхээр шууд гэрээ байгуулсан “АСБИ” ХХК урьдчилгаа санхүүжилтэд 235.9 сая төгрөг авсан боловч ажлаа хийгээгүй тул ЗТАЖ-ын сайдын 2008 оны 31 дүгээр тушаалаар гэрээг цуцалжээ.
- Гүйцэтгэгч Хансуун зам ХХК Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумыг төв замтай холбох 3.2 км хатуу хучилттай замыг 2008 оны 9 дүгээр сарын 15-нд ашиглалтад өгөхөөр гэрээ байгуулсан боловч 1.2 км шороон зам зассанаас өөр ажил хийлгүй орхисон, аймгийн төвийн 1 км хатуу хучилттай авто замын шинэчлэлийг гүйцэтгэсэн боловч аймгийн БХБА-наас шалгаад 650.7 метр байгааг тогтоож, ашиглалтад хүлээн авахаас татгалзсан байна.
- Өндөрхаан хотын доторхи 1.7 км хатуу хучилттай замын ажлыг Харгуй ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулж, 2008 оны 12 дугаар сард 130.6 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч одоо болтол ажил эхлүүлэх арга хэмжээ аваагүй байна.

3.34 ЗТАЖЯ /хуучин нэрээр/ 2008 оны ЗБА-ын гэрээг өнөөг хүртэл дүгнээгүй байна.

3.35 Орхон аймгийн Баян-Өндөр, Жаргалант сумдын халуун усны БУА-ыг хүйтний улиралд эхлүүлэхээр гэрээ хийж, урьдчилгаа санхүүжилтийг 60-70%-иар олгосон нь Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар баталсан журмын 3.5 дахь заалтыг зөрчсөн ба гэрээт ажил хугацаа хожимдох, чанаргүй хийгдэх нөхцөлийг бүрдүүлсэн байна.



3.36 Баянхонгор аймгийн Баацагаан сумын халуун усны барилгын гүйцэтгэгч “Баянтосон” ХХК халуун усны барилга шинээр барилгүй, сумын 9 жилийн сургуулийн халуун усны хуучин барилгад засвар хийсэн, Өлзийт сумын халуун усны барилгыг зураг төсвийн дагуу гүйцэтгээгүйгээс гадна стандартын бус материал ашиглажээ.

3.37 Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын халуун усны барилгыг зориулалтын бус хөөсөн блокоор барьсан, улсын комисс хүлээж аваагүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын халуун усны барилгыг ашиглалтад хүлээн аваагүй, шинээрээ тоногдож эхэлсэн, Ховд аймгийн Алтай сумын халуун усны барилга сумын төв нүүж ирээгүйгээс тогтмол ажиллаагүй, данс бүртгэлд тусгагдаагүй байна.

**Гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчтэй хариуцлага тооцоогүй байна**

***Эрдэс баялаг, эрчим хүчний яам:***

3.38 Дорноговь аймгийн Хатанбулаг суманд Монгол алт ХХК-ийн 2007 онд барьсан 890.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй салхин ЦС-ын 15 сэнсний 7 ажилладаггүй, тоног төхөөрөмж нь чанарын шаардлага хангахгүй байгаа тул ЭБЭХ-ний сайдын 2009 оны 38 дугаар тушаалаар томилогдсон ажлын хэсэг газар дээр нь шалгаж, үйл ажиллагааг нь зогсоожээ.

3.39 Өвөрхангай аймгийн Богд сумын төвд 2007 оны 10 дугаар сард ашиглалтад орсон 392.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй дизель, салхи хосолсон цахилгаан үүсгүүр 5 сар ажиллаад эвдрэл гарч, гүйцэтгэгч компани засварласан боловч чанарын шаардлага хангахгүйгээс сэнсний аккумулятор цэнэглэгдэхгүй болсон, салхины хурд хэмжигч багаж эвдэрсэн, 1 сэнсний үзүүрийн хэсэг цуурсан байна.

3.40 Уг үүсгүүр ашиглалтад орсноос хойшхи 2 жилийн хугацаанд 9 сар сумын төвийн хойд хэсгийн айл өрхийг хоногт 2-4 цаг цахилгаанаар хангажээ.

3.41 Эдгээр дутагдал нь хөрөнгө оруулалтын ажлын явцад захиалагчийн талаас тавих хяналт хангалтгүй байгаагаас гадна түүнд ашиглагч байгууллагуудыг оролцуулаагүйгээс тодорхой хэмжээгээр шалтгаалжээ.

3.42 2008 онд ДШС-ний шинэчлэл төслийн хүрээнд шинээр 7, урьд оноос шилжиж ирсэн 1 ажил хийгдсэнээс Бэрх тосгоны ДШС, зуухны шинэчлэлийн ажил дууссан боловч өмчлөлийн асуудал шийдэгдээгүй тул комисс ажиллах боломжгүй, 2007 оноос хийгдэж эхэлсэн Дарханы ДШС-ний ажил дуусаагүй байна.

3.43 Баянхонгор аймгийн Бууцагаан сумын 35 кв-ын ЦДАШ-ын тендерийн үйл ажиллагааны талаархи маргаан гомдол гаргагчийн талд шийдвэрлэгдсэн ба

Такашкен боомт-Булган сумын 35 кв-ын ЦДАШ-ын тендерийн асуудлыг СЯ одоогоор хянаж байна.

3.44 Дэлхийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа ЭХ-ний төслийн хүрээнд УБЦТС ТӨХК-ийн Сонгинохайрхан салбарын түгээх сүлжээний шинэчлэлийн БУА-ыг гүйцэтгэхээр Алтай трест ХХК шалгаран 2005 оны 8 дугаар сард 657.3 сая төгрөгийн үнэ бүхий гэрээг байгуулж, 2005-2007 онд гэрээний үнийн дүнгийн 64 хувь буюу 423.5 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгожээ. Материалын нийлүүлэлт болон бусад шалтгааны улмаас гэрээг 2007, 2008 онд 2 удаа сунгаж, гүйцэтгэгч 2008 оны 10 дугаар сард ажлыг дуусгах үүрэг хүлээсэн боловч өнөөгийн байдлаар ажлын гүйцэтгэл 48 хувьтай байна.

3.45 Гэвч захиалагч гэрээний тусгай нөхцөлийн 46 дугаар заалтын дагуу хоног тутамд дутуу ажлын үнийн дүнгийн 0.1 хувиар хариуцлага тооцоогүй байна.

***Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам:***

3.46 ЗТАЖЯ ЗБА-ын 2007 оны гэрээг 2008 оны 4 дүгээр сард дүгнэж, 7 гүйцэтгэгчийн гэрээг газар чөлөөлөхөд хүндрэл үүссэн, материалын үнэ өссөн зэрэг шалтгааны улмаас нэмэлт алданги тооцохгүйгээр сунгаж, барилгын ажлын тодотгосон төлөвлөгөөг хугацаанд нь гаргаж өгөөгүй 20 гүйцэтгэгчийг 16,5 сая төгрөгөөр торгосон боловч торгуулийн мөнгийг ажлын гүйцэтгэлээс бүрэн суутгаж аваагүй байна. Тухайлбал, Хархорин-Цэцэрлэг чиглэлийн зам барьж байгаа АСБИ, Нутгийн зам ХХК-иудыг 2.0 сая төгрөгөөр, Дашинчилэн-Орхоны гүүрийн зам барьж байгаа Эрдэнэт суварга ХХК-г 3.0 сая төгрөгөөр, Хархорин-Хужирт чиглэлийн зам барьж байгаа Хархорин АЗЗА, Аваргас ХХК-иудыг 2.0 сая төгрөгөөр торгох арга хэмжээ авахаар яамны ТНБД-ын тушаал гарсан боловч санхүүжилтээс суутгаж аваагүй байна.

## **Бүлэг 4 Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн хяналт хангалтгүй байна**

**Төрийн байгууллагуудын ажлын уялдаагүйгээс хөрөнгө оруулалтын үр ашиг буурч байна**

**Эрдэс баялаг, эрчим хүчний яам:**

4.1 2008 онд Эрдэс баялаг, эрчим хүчний салбарын хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн 22,284.2 сая төгрөгийг улсын төсвийн эх үүсвэрээр, 42,637.4 сая төгрөгийг Монгол Улсыг хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн байна.

4.2 Тайлант онд байгууллагын өөрийн хөрөнгөөр ЭХСХТ 221.4 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, их засвар, тоног төхөөрөмжийн, АМГТХЭГ 76.8 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийн худалдан авалт тус тус хийсэн байна.

4.3 2008 онд ЭХ-ний салбарт хэрэгжүүлсэн гадаадын зээлийн 14,961.3 сая төгрөгийн, тусламжийн 750.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг аудитад хамрууллаа. Чех улсын буцалтгүй тусламжаар хэрэгжиж байгаа “Цахилгаан тоног төхөөрөмжийг шинэчлэх” төслийн хүрээнд ДЦС-4 ТӨХК-ийн түлш дамжуулах тоноглолыг автоматжуулах, ШУТИС-ийн ЭХИС-д сургалтын төв байгуулах чиглэлээр хийгдсэн ажил нь тоног төхөөрөмжийн удирдлагын автоматжуулалт, найдвартай ажиллагаа, үйлдвэрлэл-сургалтын уялдааг нягтруулахад ихээхэн үр дүнтэй хөрөнгө оруулалт болжээ.

4.4 Яамны хэмжээнд Тендерийн хуульд заасны дагуу худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж зохион байгуулах, биелэлтэд хяналт тавих, тендерийг хянах, үнэлэх ажлуудыг хэрэгжүүлэх боловсон хүчний нөөц хангалттай байгаа боловч ажлыг зөв зохион байгуулаагүй, салбарын бодлого тодорхойлох үүрэгтэй яамны албан тушаалтнууд тендерийн комисс болон үнэлгээний хороонд ажиллаж байгаа нь зохимжтой бус байна.

4.5 Монгол Улсын 2008 оны төсвийн тухай хуулиар батлагдаж, төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 328.5 сая төгрөгийн автомашин, тээврийн хэрэгслийг ТӨХ зөвшөөрөл өгөөгүйгээс улсын дугаар аваагүй, өнөөг хүртэл ашиглаагүй байна. Тухайлбал, АМГТХЭГ-ын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу бэлтгэсэн автобус, Pick Up маркийн 8 автомашинд дээрх шалтгааны улмаас улсын дугаар авч чадаагүй, ашиглагдаагүй 6-9 сар болжээ.

**Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам:**

4.6 ЗТБХБ-ын салбарын хөрөнгө оруулалтын өртгийн нилээд хувийг эзэлдэг шатах тослох материал, битум, цемент, арматурын үнэ урьд оноос 50-90 хувь өссөнөөс шалтгаалан 37 гэрээт ажилд нийт 11.5 тэрбум төгрөгийн үнийн зөрүүг олгох хүсэлтийг СЯ-нд тавьсан боловч шийдвэрлэгдээгүй, гүйцэтгэгч компаниудын



дотоод зохион байгуулалт сул, тоног төхөөрөмж, ИТА-ын тоо хангалтгүй байсан нь 2008 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө 17.1 хувиар тасрахад нөлөөлжээ.

4.7 ЗБА-ын урьдчилгаа төлбөрийг гэрээт хугацаанаас 14-34 хоногоор хожимдуулан олгосон, шаардагдах тоног, төхөөрөмж, материалыг хил, гаалиар оруулах зөвшөөрлийг СЯ 153 хоногоор саатуулсан, НХХЯ ажиллах хүч гаднаас оруулж ирэх зөвшөөрлийн тоог бууруулан хугацаа алдаж олгосон, ажлын байрны төлбөрөөс чөлөөлөөгүй зэрэг нь БНСУ-ын “Hanshin Engineering and Corporation” компани гүйцэтгэгчээр ажиллаж буй Чойр-Сайншанд чиглэлийн 176.4 км хатуу хучилттай авто зам барих төслийн хэрэгжих хугацааг хэтрүүлэхэд нөлөөлжээ.

4.8 ЗГ-ын хуралдаанаас шаардагдах нэмэлт санхүүжилтийг яаралтай шийдвэрлэхийг ЗТБХБЯ, СЯ-нд үүрэг болгосон боловч тодорхой арга хэмжээ аваагүй байна.

4.9 “Hanshin Engineering and Corporation” компани төлөвлөсөн ажлаа зохих түвшинд хийгээгүй, туслан гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулах болон ЗБА-ын бэлтгэлд хугацаа алдсанаас 2008 онд нийт ажлын 13.0 хувийг гүйцэтгэж, гэрээг цуцалжээ.

4.10 Ашиглалтад өгсний дараагийн жилээс эхлэн 3 жилийн хугацаанд улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх УБ-Лүн чиглэлийн 106.2 км асфальт-бетон хучилттай 21,238.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг гүйцэтгэхээр 2007 онд “Очир төв” ХХК шалгарч, 2008 оны 11 дүгээр сарын 1-нд ашиглалтад оруулах гэрээ байгуулсан боловч 45 км авто замын асфальт бетон хучилт хийж, нийт төсөвт өртгийн 58.5 хувь буюу 12.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг дуусган, 61.1 км авто замын суурь, хучилтын ажил хийгдээгүй дутуу байна.

4.11 Ажлыг үргэлжлүүлэхэд санхүүгийн эх үүсвэр дутагдаж байгаа ба хийсэн ажлын гүйцэтгэлээр барьцаалж арилжааны банкнаас зээл авах, эсвэл хийгдсэн ажлын гүйцэтгэлээс 3-4 тэрбум төгрөгийг төсвөөс олгуулах замаар асуудлыг шийдвэрлэхээр ажиллаж байгааг харгалзан, хугацааг 113 хоногоор буюу 2009 оны 8 дугаар сарын 21 хүртэл сунгасан байна.

4.12 МУХС-ийн хөрөнгөөр 2007-2009 онд баригдах Баянголын амны 32,472.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй орон сууцны хорооллыг дулаанаар хангах инженерийн ШС-ний 1 дүгээр ээлжийн ажил бүрэн дуусч 2, 3 дугаар ээлжийн ажлын 80-90 хувь хийгдсэн ба санхүүжилт хугацаандаа олгогдохгүй 2-3 сараар хүлээгдсэнээс шаардлагатай тоног төхөөрөмжийг авч чадахгүйд хүрч, гэрээг 2009 оны 10 дугаар сар хүртэл сунгажээ.

4.13 Хөрөнгө оруулалтын хэрэгжилт, гүйцэтгэлд АЗГ-ын инженерүүд газар дээр нь хяналт тавьж байхад ЗТБХБЯ, СЯ-ны 13 албан тушаалтан гүйцэтгэлд гарын үсэг зурж, хяналт шалгалтын ач холбогдлыг зарим талаар бууруулж, илүү шат дамжлагыг бий болгож байна.

**Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг хянах дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоо бүрдээгүй байна**

***Эрдэс баялаг, эрчим хүчний яам:***

4.14 Алтай трест ХХК-ийн 2007 онд гүйцэтгэсэн Улаангом-Малчин-Хяргас-Зүүнговь-Баруунтуруун сумдыг холбосон 110 кВ, 35 кВ, 10 кВ-ын ЦДАШ-ын нийт

тулгуур шонгийн 98 хувь хазайсан, 5 шон хугарсан байна.

4.15 Энэ нь хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд тавих захиалагчийн хяналт хангалтгүй, техникийн, ажлын болон улсын комисс хариуцлагагүй ажилласныг харуулж байна.

4.16 Дарханы ДЦС ХК-ийн 8, 9 дүгээр зуухны шинэчлэлийн ажил дууссан боловч гүйцэтгэгч байгууллага баримт материалаа ирүүлээгүйгээс бүртгэлд аваагүй байна.

4.17 2008 онд улсын төсвийн хөрөнгөөр 1,189.6 сая төгрөгийн ЭХ-ний зураг, төсөл, ТЭЗҮ, хайгуул судалгааны ажил хийгдэж, санхүүжигдсэн боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын 4.47-д “Биет бус хөрөнгөд . . .судалгаа хөгжүүлэлтийн зардал орно”, 4.48-д “Биет бус хөрөнгийг анхны үнээр бүртгэнэ” гэж заасны дагуу биет бус хөрөнгөд бүртгээгүй байна.

***Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам:***

4.18 Авто замын салбарт 2008 онд хөрөнгө оруулалтаар хийгдсэн 54 гэрээт ажлын 28.9 тэрбум төгрөгийн 62 гүйцэтгэлийг АЗХСТ хянан баталгаажуулжээ.

4.19 Авто замын барилга, үйлдвэрлэлийн хэлтсийн инженерүүд 2008 онд гүйцэтгэгч байгууллагуудад 425 албан шаардлага, ажил гүйцэтгэх 86 зааварчлага өгч, ажлын талбай дээр 15.2 мянган удаа туршилт, шинжилгээ хийсэн байна.

4.20 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2006-2008 онд 102 суманд нийт 1,020.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ус зөөлрүүлэх тоног төхөөрөмж суурилуулснаас Говь-Алтай, Сүхбаатар, Завхан аймгийн 14 суманд суурилагдсан тоног төхөөрөмжүүд бүртгэлд тусгагдаагүй, Завхан аймгийн 5 суманд суурилагдсан тоног төхөөрөмж ашиглалтгүй байна.

4.21 Авто замын тухай хуулийн 14.2.4-т “Авто зам, замын байгууламжийг ашиглалтад хүлээн авч, тайлан бүртгэлдээ тусган, арчлан хамгаалагчийг тогтоох”, Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.24-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн барилга байгууламж, их засварын ажил, худалдан авсан тоног төхөөрөмжийг ашиглалтад хүлээн авсан гүйцэтгэлийн эцсийн дүнгээр тухайн төсөл хэрэгжсэн төсөвт байгууллагын санхүүд бүртгүүлэн, тайлан балансад тусгах арга хэмжээг Захиалагч байгууллага хариуцан гүйцэтгэнэ” гэж заасныг зөрчиж 2007-2008 онд ашиглалтад оруулсан 12.9 тэрбум төгрөгийн өртөгтэй зам, гүүрийг захиалагч нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна.

Аудитаар дэд бүтцийн салбарт нийт 909.3 сая төгрөгийн төлбөрийн акт бичиж, 22,783.4 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага өглөө.




## Дүгнэлт

Аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулахдаа Засгийн газрын болон салбарын дунд, урт хугацааны хөтөлбөр, зорилтод тусгагдсан төсөл, арга хэмжээг ач холбогдол, хүлээгдэж буй үр дүнгээр нь эрэмбэлэн санхүүжүүлэх зарчим хэрэгжихгүй, олон жижиг зүйлийг хамруулсан, ач холбогдлыг сайн ойлгуулаагүй зэргээс төсвийг хянах, хэлэлцэн батлах явцад их хэмжээгээр өөрчлөгддөг, тодотгосон төсвөөр нэмж баталсан зарим ажил хийгдээгүй нь төлөвлөлтийн үндэслэл хангалтгүй байсныг харуулж байна.
- Техникийн нөхцөл, төсөв, зураг төсөл дутуу, ТЭЗҮ хийгдээгүй байхад БУА-ыг эхлүүлснээс ажил удаашрах, нэмэлт санхүүжилт шаардагдах нөхцөл бүрдэж байна.
- Төсвийн тухай хуульд тусгагдсан төсөл, арга хэмжээ бүрээр мэдээллийг бүрэн гаргаагүй, цахим хуудаст тендерийн урилга, үр дүнг нийтлээгүй, тендер шалгаруулалтын хавтаст хэргийг бүрэн бүрдүүлж, архивын нэгж болгон хадгалаагүй, архивын эмх цэгц, баримт хүлээлцсэн байдал шаардлагын хэмжээнд хүрээгүй байна.
- Тендерийн үнэлгээний хорооны гишүүдийн дийлэнх нь мэргэжлийн сургалтад хамрагдаагүй, мэргэшсэн төсөвчин байхгүй, үнэлгээг нарийвчлан хянах тогтолцоо бүрдээгүй, хугацаа богино байгаа нь тендерийг үнэлэх ажлын чанарт муугаар нөлөөлжээ.
- Гүйцэтгэгчийг буруу сонгох, БУА-ыг зураг төсвийг нь баримтлахгүйгээр чанаргүй хийх, стандартын бус материалаар барих, гүйцэтгэлийг хуурамчаар тайлагнах, тендерийн хуулийн 46.1.8-д "...тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинжтэй бараа, үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн 1 дүгээр сарын 15-ны дотор эхлүүлэх"-ээр заасныг зөрчсөн зэрэг нь захиалагчийн хяналт хангалтгүй байсантай холбоотой бөгөөд хугацааг хэтрүүлэх гол нөхцөл болж байна.
- Хөрөнгө оруулалтын ажлын гэрээг алданги тооцохгүйгээр сунгасан, гүйцэтгэгчдэд урьдчилгаа санхүүжилт олгосон боловч ажил хийгдээгүй, тооцсон алдангийг гүйцэтгэгчдээр хүлээн зөвшөөрүүлж, барагдуулах ажлыг зохион байгуулаагүй байна.
- Тендерийн хууль, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд хөрөнгө оруулалтын ажлын явцад хариуцлага болон алданги тооцох талаар тодорхой заалтгүй, хариуцлагыг зөвхөн гэрээ цуцлах байдлаар тооцохоор байгаа нь гэрээний үнэ өсөх, хугацаа алдах зэрэг эрсдэлийг үүсгэж байна.
- Захиалагчийн хяналтаас гадна яамдын албан тушаалтнууд гүйцэтгэлд гарын үсэг зурж байгаа нь хяналт шалгалтын ач холбогдлыг зарим талаар бууруулж, илүү шат дамжлагыг бий болгож байна.
- Захиалагчийн хяналт, техникийн болон ажлын комиссын ажил хангалтгүйгээс хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн чанарт доголдол гарч байна.
- Төрийн байгууллагуудын ажлын уялдаа муугаас татварын хөнгөлөлт, зөвшөөрөл, санхүүжилтийг хугацаа алдаж олгосноос гэрээт ажлын хугацаа хэтрэх, хөрөнгө оруулалтын үр ашиг буурах нөхцөл бүрдсэн байна.

**Холбогдох байгууллагын санал**



**Эрдэс баялаг, эрчим хүчний салбар:**

  
**МОНГОЛ УЛСЫН  
ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ  
САЙД**  
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,  
Утас: 32-63-67, Факс: (976-11) 31-13-81  
2009.07.03 № а/1781  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

□ **МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ** □

Улс, орон нутгийн төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сан, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2008 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж дараах санал, тайлбарыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 2 хуудас

  **Д.ЗОРИГТ**

0800932

## Хавсралт

Улс, орон нутгийн төсөв, МУХС, гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр 2008 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлангийн төсөлд өгөх санал, тайлбар

№	Тайланд тусгагдсан заалт	Тайлбар, найруулга /өөрчлөх санал/
1,10	Барилга захиалагчийн дүрмийн “Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг бага зардлаар илүү үр дүнд хүрэх шаардлагад нийцүүлэн боловсруулах” заалт бүрэн хэрэгжихгүй үнэлгээний хорооны гишүүдийн дунд мэргэшсэн төсөвчин байдаггүй үнэлгээг нарийвчлан хянах тогтолцоо байхгүй байна.	2007-2008 онд баригдсан ЦДАШ, дэд станцын зураг төсөл урьдчилан хийгдээгүй байснаас шалтгаалан зарим шугамын уртад зөрүү гарсан боловч гүйцэтгэлээр нь санхүүжүүлсэн тул улсад хохирол учраагүй. Тендерт ялсан компаниудын нийлүүлж байгаа тоног төхөөрөмж нь зураг төсөлд тусгагдсан тоног төхөөрөмж, материалын үзүүлэлттэй хир нийцэж байгаад хяналт тавьж ажиллаж байна. Харин зураг төслийг захиалан хийлгэхдээ тухайн объектод тусгагдсан тоног төхөөрөмж, материал нь манай орны цаг уурын нөхцөлд хир нийцэж байгаа болон дэвшилттэй тоног төхөөрөмж эсэхэд хяналт тавьж ажиллаж ирсэн. 2007 оны хувьд ЦДАШ, дэд станцын зураг төсөл, барилга угсралтын ажлыг хамтад нь түлхүүр гардуулах шууд гэрээ байгуулан хийлгэсэн. Захиалагчийн хуучин дүрмийг дээрх байдлуудтай уялдуулан өөрчлөж 2009 оны 3 дугаар сарын 18-нд ЗГ-ын 73 тоот тогтоолоор баталсан.
1,11	Цогтцөций шугам зурагт 12,4 км ЭХСХТ-ын техникийн нөхцөлд 18 км гэсэн	Техникийн нөхцөлийг орон нутгийн эрчим хүчний ашиглалтын байгууллага өгдөг. Шугамын трассыг зургийн байгууллага, захиалагчтай хамтран аль болох богино, гэхдээ ашиглалтын үед хүндрэлгүй байх трассыг сонгох ёстой. Харин техникийн нөхцөл болон зургийн даалгаварт тусгагдсан зай хэмжээ нь ойролцоо эсвэл машин зам дагасан байх жишээтэй байдаг. Техникийн нөхцөл, зургийн даалгавар нь хаанаас ямар тоноглолоор дамжуулан тэжээл авах, ямар хэмжүүр, хамгаалалт, холбоо тавих, гэх мэт-ийг зааж өгсөн байх ёстой. Тавантолгой-Цогтцөцийн 10 кВ-ын ЦДАШ, дэд станцын БУА-ын гүйцэтгэгчийг ажлын зургийг өгч тендерээр сонгосон. Иймд Цогтцөцийн хувьд 5,6 км шугамыг хэмнэж трасс гаргасан нь 50 орчим сая төгрөг хэмнэсэн.
1,11	Цогт-Овоогийн зурагт тулгуур 399, зургийн паспортонд 841-гээр зөрүүтэй заасан	ЦДАШ-ын барилга угсралтын нэг маягийн альбом байдаг. Үүний дагуу тулгууруудыг зурагт дугаараар байрлуулсан байдаг тул зурагт тусгагдсан тулгуурын тоогоор тулгуурууд угсрагдсан
1,11	Баянлигийн дэд станцыг өөр зургаар барьж эхэлсэн	Дэд станцын нэг маягийн зураг байдаг. Энэ нэг маягийн зургийг хуулбарлан тухайн газар нутагт холболт, байрлалыг өөрчлөн байрлуулдаг. Зургийн байгууллага андуурч өөр дэд станцын зураг хавсаргасан байсныг өөрчлөн БУА-ыг гүйцэтгүүлсэн болно
1,11	ЦДАШ-ын Хөвсгөл, Баянхонгор аймагт баригдаж буй Мөрөн-Алаг-Эрдэнэ-Хатгал-Чандмань-Өндөр, Баянхонгор-Бөмбөгөр-Бууцагаан зэрэг 6 шугамын урт 100 км-ээс дээш гарч багтаамжийн гүйдэл зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрчээ. Гэтэл зураг төсөлд нум унтраах реактор суурилуулах асуудлыг	Хөвсгөл болон Баянхонгор аймгийн төвийн 110/35/6 кВ-ын дэд станцад РЗДСОМ-620/35 нум унтраах реактор тавьсан байгаа. Цаашдаа дээрх дэд станцуудыг нэг трансформатораар өргөтгөхөөр “ТБЦДС” ТӨХК зураг төслийг хийлгэх гэж байна. Энэ зураг төсөлд нум унтраах реакторын чадлыг нэмэгдүүлэх ажлыг тусгана.

	цахилгаан байгууламжийн дүрмийн шийдээгүй 1.2.8-ын дагуу	
3.2	Захиалагч байгууллагаас өгсөн техникийн нөхцөл, зургийн даалгавар, газар орны онцлогийг бодитой тусгасан ажлын зураг, төсөвгүй байхад 2007 онд шууд гэрээ байгуулан ажил эхлүүлснээс гэрээний дагуу санхүүжилт авсан ЦДАШ-ын урт нь ажлын зурагт тусгагдсанаас ихээхэн зөрүүтэй гарч 41 объектод 4947,3 сая төгрөгийн санхүүжилтийг илүү, 1128,0 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгожээ. Хавсралт 1-ээс үзнэ үү.	Захиалагч байгууллагаас өгсөн техникийн нөхцөл, зургийн даалгавар, газар орны онцлогийг бодитой тусгасан ажлын зураг, төсөвгүй байхад 2007 онд шууд гэрээ байгуулан ажил эхлүүлсний дараа гэрээнд тусгагдсан ЦДАШ-ын урт нь ажлын зурагт тусгагдсанаас ихээхэн зөрүүтэй гарч 41 объектод 4947,3 сая төгрөгийн илүү санхүүжилт олгогдох байсныг шалган үзэж 4947,3 сая төгрөгийг санхүүжилтээс нь суутган тооцож 2008 оны Улсын төсвийн тодотголд тусгуулан батлуулсан. Иймд гүйцэтгэгч компаниудад илүү санхүүжилт олгож Улсад хохирол учруулаагүй болно.
3.3	Шугамын уртыг дутуу тооцсон 14 объектын нэмэлт санхүүжилтэд 1128,0 сая төгрөгийг гүйцэтгэгч компаниудад буцаан олгохоор 2008 оны төсөвт төлөвлөж батлуулсан боловч илүү олгосон 4947,3 сая төгрөгийг хураан барагдуулж улсыг хохиролгүй болгох ажил одоо болтол хийгдээгүй байна	Шугамын уртыг дутуу тооцсон 14 объектын цахилгаан дамжуулах агаарын шугамын километрийн урт нэмэгдсэн нь улсын экспертизээр баталгаажуулсан зураг, шугамын трасс хүлээлгэн өгсөн актаар нотлогдсон бөгөөд шугамын уртын зөрүүгээр мэргэцсэн төсөвчнөөр төсөв хийлгэж нэмэлт санхүүжилтийн дүнг баталгаажуулсан тул шаардлагатай нэмэлт хөрөнгийн эх үүсвэрийг 2009 оны Улсын төсвийн тодотголд тусгуулах арга хэмжээ авах нь зүйтэй. 4947,3 сая төгрөгийг санхүүжилтээс нь суутган тооцож 2008 оны Улсын төсвийн тодотголд тусгуулан батлуулсан. Иймд гүйцэтгэгч компаниудад илүү санхүүжилт олгож Улсад хохирол учруулаагүй болно.

**Зам тээвэр, барилга, хот байгуулалтын салбар:**



**МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА,  
ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
ЯАМ**

15170 Улаанбаатар хот,  
Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай 3,  
Утас: 31-06-12, Факс: (976-11) 32-29-04  
E-mail: webmaster@mrtcad.gov.mn

2009.07.03 № 4/2527


танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ**

2008 онд Улс, орон нутгийн төсөв, МУХС, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлагналын төсөлтэй танилцлаа.


Тайланд дурьдсан зөвлөмж, дүгнэлттэй холбогдсон зарим тайлбаруудыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 2 хуудастай.



ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА Ж.БАТ-ЭРДЭНЭ

03 02823



ЗТБХБЯ-ны 2009 оны 4/2527 тоотын хавсралт

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРААС ЗТБХБ-ЫН 2008 ОНД УЛС,  
ОРОН НУТГИЙН ТӨСӨВ, МУХС, ГАДААДЫН ЗЭЭЛ ТУСЛАМЖИЙН  
ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖҮҮЛСЭН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ШАЛГАЛТЫН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАГНАЛЫН  
ТӨСӨЛД ТАШАА ОЙЛГОЛТООР ТОДОРХОЙЛОГДСОН  
ЗААЛТУУДАД ӨГӨХ ТАЙЛБАР

3.31. 2008 онд хөрөнгө оруулалтаар нийт 670 гаруй км хатуу хучилттай авто зам, 860 гаруй уртааш метр төмөр бетон болон модон гүүрийн ажил хийхээр тооцсоноос 128.6 км хатуу хучилттай авто зам ашиглалтанд оруулсан нь 19.2 хувьтай, 403.5 км уртааш метр төмөр бетон болон модон гүүрийг ашиглалтанд өгсөн нь 46.9 хувьтай байна.

Тайлбар:

Дээрх замын урт нь 2008 онд ашиглалтанд орохоор гэрээ байгуулагдсан боловч тухайн жилийн төсөвт хөрөнгө бүрэн тусгагдаагүй, шатах тослох материал болон зам барилгын гол түүхий эд битумны үнэ өссөн, ялангуяа “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн БНСУ-ын зээлээр хэрэгжиж байгаа 176.4км замын гүйцэтгэгчийн гэрээнд НӨАТ, гаалийн татвараас чөлөөлөх заалт байхгүй зэрэг шалтгаанаар төлөвлөсөн замууд ашиглалтад орж чадаагүй болно. Санхүүжилт нь гүйцэтгэлийн дагуу хийгдсэн болно.

3.32. Гэрээний гүйцэтгэлийг Тендерийн хууль, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний заалтуудаар дүгнэж байгаа боловч тэдгээрт ажил дүгнэх, хариуцлага болон алданги тооцох ажлыг явц дунд хийх тодорхой заалт байхгүйгээс хариуцлагыг гэрээ цуцлах байдлаар тооцоход гэрээний үнэ өсөх, хугацаа алдах зэрэг эрсдэлүүд бий болж байна.

Тайлбар: Холбогдох хууль, тогтоомж, жишиг бичиг баримтын дагуу гэрээ байгуулж, гэрээний нөхцлийн дагуу хариуцлага тооцон ажиллаж байна. Цаашид ажлын хариуцлагыг дээшлүүлэх үүднээс гэрээний нөхцөлд тодорхой заалт оруулан ажиллах болно.

3.33. Тендерийн хуулийн 34.4-т Улсын төсвийн хөрөнгөөр барьж байгуулах авто зам, ЭХ-ний төслийн хөрөнгө оруулалтын хэмжээ нь тухайн чиглэлийн үйл ажиллагаа эрхэлдэг дотоодын нийт ААН-үүдийн хүчин чадалтай тэнцүү буюу түүнээс дээш хэтэрсэн тохиолдолд ЗГ-н жишиг үнийг үндэслэн, гүйцэтгэгчийг сонгох шаардлагатай гэж үзсэн бол шууд гэрээ байгуулах гэж заасныг үндэслэн компаниудтай гэрээ байгуулсан боловч үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчидтэй хариуцлага тооцоогүй байна.

- Гүйцэтгэгч Хансуун зам ХХК Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумыг төв замтай холбох 3.2 км хатуу хучилттай замыг 2008 оны 9 дүгээр сарын 15-нд ашиглалтанд өгөхөөр гэрээ байгуулсан байгуулсан боловч 1.2 км шороон зам

зассанаас өөр ажил хийлгүй орхисон, аймгийн төвийн 1км хатуу хучилттай авто замын шинэчлэлийг гүйцэтгэсэн боловч аймгийн БХБА-наас шалгаад 650.7 метр байгааг тогтоож ашиглалтад хүлээн авахаас татгалзсан байна.

- Өндөрхаан хотын доторхи 1.7 км хатуу хучилттай замын ажлыг Харгуй ХХК гүйцэтгэхээр гэрээ байгуулж, 2008 оны 12 дугаар сард 130.6 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч одоо болтол ажил эхлүүлэх арга хэмжээ аваагүй байна

Тайлбар:

Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумыг төв замтай холбох 3.2 км хатуу хучилттай зам нь **шууд гэрээгээр хийгдээгүй**, гүйцэтгэгчийн тендер зарлаж, сонгон шалгаруулж гэрээ байгуулсан боловч зам барилгын материалын үнийн өсөлт, тухайн гүйцэтгэгчийн чадвараас шалтгаалсан болно. Ийм гэрээний заалтын дагуу холбогдох арга хэмжээг авч ажиллана.

“Хансуун зам” компанийн гүйцэтгэсэн аймгийн төвийн 1км замын шинэчлэлт болон “Харгуй” компанийн гүйцэтгэхээр гэрээ байгуулсан 1.7км замын ажлыг **орон нутаг гүйцэтгэгчийг шалгаруулж**, гэрээ байгуулж, хяналт тавьж ажилласан байна.

3.46. ЗТАЖЯ ЗБЯ-н 2007 оны гэрээг 2008 оны 4 дүгээр сард дүгнэж, 7 гүйцэтгэгчийн гэрээг газар чөлөөлөхөд хүндрэл үүссэн, материалын үнэ өссөн зэрэг шалтгааны улмаас нэмэлт алданги тооцохгүйгээр сунгаж, барилгын ажлын тодотгосон төлөвлөгөөг хугацаанд нь гаргаж өгөөгүй 20 гүйцэтгэгчийг 16.5 сая төгрөгөөр торгосон боловч торгуулийн мөнгийг ажлын гүйцэтгэлээс бүрэн суутгаж аваагүй байна. Тухайлбал Хархорин-Цэцэрлэг чиглэлийн зам барьж байгаа АСБИ, Нутгийн зам ХХК-иудыг 2.0 сая төгрөгөөр, Дашинчилэн-Орхоны гүүрийн зам барьж байгаа Эрдэнэт суварга ХХК-г 3.0 сая төгрөгөөр, Хархорин-Хужирт чиглэлийн зам барьж байгаа Хархорин АЗЗА, Аваргас ХХК-иудыг 2.0 сая төгрөгөөр торгох арга хэмжээ авахаар яамны ТНБД-н тушаал гарсан боловч санхүүжилтээс суутгаж аваагүй байна.

Тайлбар: Хариуцлага тооцож торгууль оногдуулсан компаниудын гүйцэтгэлээс суутган авах зарчимаар торгуулийг авч байгаа бөгөөд дээрхи нэр заасан компаниудаас гүйцэтгэл ирээгүй, мөн зарим компанитай гэрээ цуцлагдсан байгаа болно.

- ❖ Байршил тодорхойгүй гэж бүртгэгдсэн авто замын чиглэлийг тогтоох

Тайлбар: Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан замууд нь Монгол улсын авто замын сүлжээг үндэслэн байршилын дагуу бүртгэлд авагдсан болно.

\_\_\_\_\_оОо\_\_\_\_\_

## ҮАГ-ын тайлбар: (ЭБЭХЯ-наас ирүүлсэн саналын хариу)

Тайлбар 1.	Хөрөнгө оруулалтын ажлын төсвийг бодитой зохиох, төсвийн үнэлгээг нарийвчлан хянахгүй байна гэсэн дүгнэлтэд ирүүлсэн тайлбарт зураг төсөлд тусгагдсан тоног төхөөрөмж манай орны нөхцөлд нийцэж байгаа эсэх, зурагт заасан тоног төхөөрөмжийг нийлүүлсэн эсэхэд хяналт тавьж ажилласан тухай буюу өөр асуудал дурьдсан тул хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 2.	Ирүүлсэн тайлбарт техникийн нөхцөл, зургийн даалгаварт хаанаас ямар тоноглолоор дамжуулан тэжээл авах, ямар хэмжүүр, хамгаалалт, холбоо тавих г.м-ийг заадаг гэжээ. Гэтэл МУ-ын барилгын норм ба дүрмийн “Зураг төсөл боловсруулах, зөвшөөрөлцөх, батлах дүрэм”-ээр баталсан Цахилгаан хангамж (Өндөр хүчдэлийн дамжуулах, цахилгаан дамжуулах, дэд станц )-ын зураг төсөл боловсруулах даалгаварын үлгэрчилсэн загварт объектын бүрэлдэхүүн, хүч чадлыг шугамын урт, хэлхээий тоо, хүчдэл тус бүрээр бичнэ гэж заасан байна. Иймд тайлбарыг хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 3.	Ирүүлсэн тайлбарт зурагт тусгагдсан тулгуурын тоогоор тулгуурууд угсрагдсан гэжээ. Харин тайланд зургийн ажлын чанарыг сайжруулах, БУА-ын зургийг бүрэн бүрдүүлэх шаардлага байгааг дурьдсан тул тайлангийн 1.11-д өөрчлөлт оруулах шаардлагагүй байна.
Тайлбар 4.	Зураг төсөлтэй гэж захиалагчийг хууран Баянхонгор аймгийн Баруун баян улаан-Баянлиг сумын 35 кВт-ын дэд станцыг үнэн зөв зураг төсөлгүйгээр буюу Эрчим корпорацийн зохиосон Хөвсгөл аймгийн Арбулаг сумын дэд станцын зургийг хуулбарлан өөрсдөө хийсэн болгосон нь андуурсан үйлдэл биш тул тайлбарыг хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 5.	Хөвсгөл, Баянхонгор аймагийн зарим сумдыг холбосон ЦДАШ-ын БУА-ын зураг төсөлд нум унтраах реактор суурилуулах ажлыг тусгах шаардлагатай байгаа талаар ТБЦДС ХК-аас ЭХСХТ-д хандаж байсны дагуу уг ажил хийгдсэн байна. Тайланд зураг төслийн ажлын чанарыг сайжруулах тухай дурьдагдсан тул тайлбарыг хүлээн авах боломжгүй байна.
Тайлбар 6.7	Сангийн сайдын 2008 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 58 дугаар тушаалаар батлагдсан журмыг зөрчин захиалагч байгууллагаас өгсөн техникийн нөхцөл, зургийн даалгавар, газар орны онцлогийг бодитой тусгасан ажлын зураг, төсөвгүй байхад ажил эхлүүлсэн, 41 объектод 4947.3 сая төгрөгийн санхүүжилт илүү олгосонийг хураан барагдуулсан, улсад хохирол учруулаагүй гэх боловч эдгээр компаниудтай тооцоо нийлээгүй, гүйцэтгэгчид уг асуудлаар хуулийн байгууллагад хандан заргалдаж байгаа, Дорнод гурил компанийн гаргасан гомдол нэхэмжлэгчийн талд шийдэгдсэн, зарим компаниас төлбөрийг бүрэн гаргуулаагүй зэргээс үзвэл тайлбарыг хүлээн авах боломжгүй, аудитаар өгсөн албан шаардлагын дагуу санхүүжилтийн зөрүүгийн тооцоог гүйцэтгэгчтэй хамтран нарийвчлан хийж баталгаажуулах ажлыг хийх шаардлагатай байна.



## Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна.

### ***Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтод:***

- ❖ Түлш, эрчим хүчний салбарын норм, норматив, стандартыг боловсронгуй болгох арга хэмжээ авч, тендерт оролцогчийн ирүүлсэн зураг төсөв, техникийн нөхцөл, үндэслэлийг хянах оновчтой тогтолцоог бүрдүүлэх арга хэмжээ авах;
- ❖ Хөрөнгө оруулалтыг салбарын хэтийн зорилт, стратеги төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөж, түүнд ТЭЗҮ, хүчдэлийн эх үүсвэр нь эцэслэн шийдвэрлэгдэж, бэлэн болсон зайлшгүй шаардлагатай ажлыг тусгаж байх;
- ❖ Улсын төсвийн хөрөнгөөр хийгдсэн ЭХ-ний зураг, төсөл, ТЭЗҮ, хайгуул, судалгааны ажлыг биет бус хөрөнгөд бүртгэх, хөрөнгө оруулалтын тооцоог нягтлан бодох бүртгэлд тусгаж, санхүүгийн тайлан гаргаж байх;
- ❖ Сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрүүдийг бий болгох талаар хийсэн хөрөнгө оруулалтын ажил чанарын шаардлага хангаагүйгээс учирсан хохирол, алдагдлыг тооцон, уг ажилд захиалагчаар ажилласан холбогдох ажилтнуудад арга хэмжээ авах;
- ❖ Санхүүжилтийг бүрэн олгосон боловч дуусаагүй хөрөнгө оруулалтын ажлыг гэрээний дагуу чанартай гүйцэтгүүлж, ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх, бүртгэлд тусгах, тендерийн хуулийн дагуу хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн баталгаат хугацааны барьцаа хөрөнгийг байршуулах дансыг Төрийн санд нээх;
- ❖ Хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх явцад хууль, журмыг баримтлаагүйгээс хөрөнгө оруулалтын үр ашгийг бууруулах нөхцөл бүрдүүлсэн албан тушаалтанд хариуцлага тооцох, архивын нэгжийг хуулийн дагуу бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;

### ***Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулгад:***

- ❖ Засгийн газрын болон салбарын дунд, урт хугацааны хөтөлбөр, зорилтод тусгагдсан төсөл арга хэмжээтэй уялдуулан хөрөнгө оруулалтыг төлөвлөх, түүний үндэслэл, үр ашгийг тооцох, чанарыг дээшлүүлэх;
- ❖ Зам, тээврийн салбарын тендерийн бичиг баримтыг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49.1, Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан журмын 3.25-д заасны дагуу архивын нэгж болгон хадгалах;
- ❖ Гэрээний гүйцэтгэлийг үнэлэх ажлыг үр нөлөөтэй болгох, барилгын ажлын явцад хариуцлага, алданги тооцох асуудлыг гэрээнд тусгаж байх;
- ❖ Ашиглалтад оруулсан зам, гүүрийг нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэлд тусгах журмыг боловсруулж, мөрдүүлэх;
- ❖ Нутгийн зам, АСБИ компаниудтай холбоотой асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэн шийдвэрлүүлэх;
- ❖ 2008 оны зам, барилгын ажлын гэрээг дүгнэж, холбогдох арга хэмжээ авах;

**ЦДАШ-ын урт /км/-ын зөрүүгээс шалтгаалан илүү болон дутуу олгогдсон  
санхүүжилтийн тооцоо**

	Төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн нэр, хүч чадал, байршил	Нийт төсөвт өртөг /сая төгрөгөөр/	ЦДАШ-ын өртөг /мянган төгрөгөөр/	Гэрээнд заасан ЦДАШ-ын ажлын урт (км-ээр)	ЦДАШ-ын ажлын урт зурагт тусгагдсанаар (км-ээр)	ЦДАШ-ын ажлын зурагт заагдсан уртаас, гэрээнд зааснаар бодож санхүүжилт олгосон уртын зөрүү			
						Санхүүжилт дутуу олгогдсон		Санхүүжилт илүү олгогдсон	
						км	дутуу км-т ногдох төсөвт өртөг	км	илүү км-т ногдох төсөвт өртөг
1	Толбо-Дэлүүн сумын 15 кВ-ын 80 км ЦДАШ, 1х0,1, 1х0,16 МВа дэд станц 2007-2008	930 000,0	739 402,0	80	73,5			6,5	68595,4
2	Өлгий-Цагаануурын 35 кВ-ын 65 км ЦДАШ, Дэд станц, 1х1.0, 1х0.25, 2007-2008	1 710 000,0	1 213 361,1	65	71,6	6,6	140673,1		
3	БНХАУ-ын хил Сүмбэр сумын 10 кв-ын 10 км ЦДАШ, 1х0.25 МБа дэд станц 2007-2007	910 000,0		65	55,8			9,2	96600,0
4	Тэлмэн-Нөмрөг сумын 35 кв-ын 89 км ЦДАШ, 1х0.4, 1х0.1, 1х0.25 МБа дэд станц 2007-2007	1 900 000,0	1 270 714,0	89	59,7			29,3	477656,2
5	Манхан-Мөст 15 кв-ын 104 км ЦДАШ, дэд станц 2007-2008	1 270 000,0	1 029 716,1	104	99,71			4,29	48498,7
6	Дөргөний УЦС-Завхан сумын 15 кв-ын 60 км ЦДАШ, дэд станц, 1х0,25, 1х0.1 мВа. 2007-2008	680 000,0	496 986,9	60	69,02	9,02	85308,2		
7	Цагаанчулуут-Отгон сумын 15 кв-ын 85 км ЦДАШ, 1х0,1, 1х0,25 мВа дэд станц 2007-2008	980 000,0	753 149,7	85	74,3			10,7	108252,2
8	Түдэвтэй-Асгат-Баянтэс сумын 10 кв-ын 105 км ЦДАШ, дэд станц 2007-2007	863 000,0	581 330,1	90	99,8	9,8	72276,3		
9	Тариалан-Эрдэнэбулган 15 кв-ын 80 км ЦДАШ, дэд станц 2007-2008	960 000,0		80	76,4			3,6	37800,0
10	Есөнбулаг-Бигэр сумын 35 кв-ын 108 км ЦДАШ, дэд станц, 1х0,25 1х0,4 мВа, 2007-2008	2 494 000,0	1 773 748,6	108	107,38			0,62	11422,9
11	Есөнбулаг-Халиун сумын 15кВ-ын 87км ЦДАШ, 1х0,1, 1х0,25 мВа дэд станц 2007-2008	1 000 000,0		87	75			12	126000,0

12	Өлгий-Толбо сумын 35 кв-ын 85 км ЦДАШ, 1х0,1, 2х0,16 МВа дэд станц дэд станц 2007-2007	1 810 000,0	1 423 373,3	85	71,1			13,9	265769,2
13	Хяргас-Баруунтуруун сумын 35 кв-ын 50 км ЦДАШ, 1х1, 1х0,1, 1х160 МВа дэд станц 2007-2007	1 200 000,0	929 167,8	50	47,5			2,5	53046,2
14	Хяргас-Зүүнговь сумын 15 кв-ын 27 км ЦДАШ, 1х1, 1х0,16 МВа дэд станц 2007-2007	350 000,0	246 340,9	27	27,54	0,54	5625,4		
15	Манхан-Зэрэг сумын 35 кв-ын 62 км ЦДАШ, 1х1,5, 1х0,1, 1х0,16 МВа дэд станц /Ховд/ 2007-2008	1 700 000,0	1 373 498,3	62	65,6	3,6	91060,1		
16	Манхан-Чандмань 15 кв-ын 65 км ЦДАШ, 1х0,1, 1х0,16 МВа дэд станц /Ховд/ 2007-2008	830 000,0	679 406,3	65	69,32	4,32	51557,3		
17	Зэрэг-Дарви 35 кв-ын 67 км ЦДАШ, 1х1, 1х0.1, 1х0.16 МВа дэд станц /Ховд/ 2007-2008	1 850 000,0	1 366 071,2	67	61,9			5,1	118729,5
18	Бөмбөгөр-Баацагаан сумын 15 кв-ын 80 км ЦДАШ, 1х1, 1х0,16 МВа дэд станц 2007-2007	930 000,0	735 131,8	80	74,3			5,7	58757,8
19	Арбулаг-Цагаан уул сумын 35 кв-ын 100 км ЦДАШ, 1х1, 1х0,16 МВа дэд станц 2007-2007	2 100 000,0	1 526 623,6	100	71,1			28,9	441194,2
20	Хатгал-Чандмань-өндөр-Цагаан үүр сумын 35,10 кв-ын 139 км ЦДАШ, 1х1, 1х0,63 МВа дэд станц 2007-2007	2 536 000,0	1 329 402,9	81,1	70,2			10,9	178674,4
20	Чандмань-Цагаан үүр сумын 10 кв-ын ЦДАШ		547 363,3	57,9	47,0			10,9	103044,2
21	Баянтээг-Баруунбаян улаан сумын 35 кв-ын 80 км ЦДАШ, дэд станц 1х0,4 2007-2007	1 840 000,0	1 334 836,9	80	65,5			14,5	271407,4
22	Арбулаг-Баянзүрх сумын 15 кв-ын 60 км ЦДАШ, 1х0,16, 1х0,1 дэд станц 2007-2008	750 000,0	562 849,4	60	49,81			10,19	109145,4
23	Баруунбаянулаан-Богд сумын 15 кв-ын 90 км ЦДАШ, 1х0,1, 1х0,16 МВа дэд станц 2007-2007	1 040 000,0	696 262,2	90	51,49			38,51	340168,5
24	Богд-Жинст сумын 15 кв-ын 32 км ЦДАШ, 1х0,16, 1х0,1 МВа дэд	430 000,0	371 373,0	32	28,63			3,37	44656,0

	станц 2007-2007								
25	Баян адрага-Дадал сумын 15 кв-ын 79 км ЦДАШ, 1х0,1, 1х0,16 МБа дэд станц 2007-2007	840 000,0	626 794,2	79	67,54			11,6	105086,3
26	Баян адрага-Норовлин сумын 15 кв-ын 83 км ЦДАШ, 1х0,1, 1х0,16 МБа дэд станц 2007-2007	880 000,0	651 338,9	83	73,4			9,6	86018,2
27	Баруунбаян-Улаан-Баянлиг сумын 35 кв-ын 110 км ЦДАШ, 1х1,0, 1х0.16, 1х0.1 мВа дэд станц 2007-2008	2 350 000,0	1 738 107,0	110	102,3			7,7	138919,8
28	Тэлмэн-Тосонцэнгэл сумын 35 кв-ын 55 км ЦДАШ, 35/10 кв-ын 2х0.1 мВа дэд станц /Завхан/ 2008	1 580 000,0	1 086 299,8	км-ын зөрүүгүй	км-ын зөрүүгүй				
29	Баянлиг-Баянговь 10 кв-ын 45 км ЦДАШ, 1х0,1, 1х0,16 мВА дэд станц /Баянхонгор/ 2007-2008	560 000,0	416 364,9	45	42,51			2,49	26305,9
30	Баянхонгор-Бөмбөгөр сумын 35 кв-ын 83 км ЦДАШ, Дэд станц, 2х1.0, 2х0.25 /Баянхонгор/ 2007-2008	2 200 000,0	1 627 889,1	83	98	15,0	335913,8		
31	Тосонцэнгэл-Төмөрбулаг сумын 10 кв-ын 52 км ЦДАШ, 1х0,1, 1х0,16 МБа дэд станц 2007-2007	675 000,0	629 643,0	52	57,97	5,97	82538,2		
32	Цагаан-уул-Могойн голын 35 кв-ын 69 км ЦДАШ, 1х0,1, 1х0,16 МБа дэд станц 2007-2007	1 800 000,0	1 246 562,2	69	72,1	3,1	63946,4		
33	Шарга-Дарви сумын 35кв-ын 100 км ЦДАШ,1х0,4, 1х0,16, 1х0,1 мВА дэд станц 2007-2008	2 200 000,0	1 767 046,4	100	100,24	0,24	4842,2		
34	Тайшир-Жаргалан сумын 35 кв-ын 56 км ЦДАШ, 1х016, 1х01 мВА дэд станц 2007-2008	1 493 000,0	1 072 110,4	56	57,63	1,63	35007,0		
35	Алаг-Эрдэнэ-Улаан Уул-Ренчин лхүм бэ-Цагааннуурын 35/15/10 кв-ын 160/75/48 км ЦДАШ, дэд станц, 2007-2008	6 405 000,0	3384658.2 1001354.3 585666.7	160 75 48	118.12 67.63 41.85			41.876 7.365 6.146	1011463.1 112275.7 85623.1
36	Шарга-Төгрөг сумын 15 кв-ын 61 км ЦДАШ, 15/0.4 кв-ын 2х0.16 мВа дэд станц. /Говь-Алтай/ 2007-2008	1 330 000,0	857 647,7	61	64,66	3,66	58755,8		

37	Тайширын УЦС- Гуулингийн 35 кВ- ын 65 км ЦДАШ, 1х0,4, 1х0,1, 1х0,25 мВА дэд станц /Говь-Алтай/ 2007- 2008	1 600 000,0	1 034 760,8	65	65,7	0,7	12723,6		
38	Тэлмэн-Идэр сумын 10 кВ-ын 50 км ЦДАШ, 1х0,1, 1х0,25 мВА дэд станц /Завхан/ 2007-2008	600 000,0		50	52,4	2,4	25200,0		
39	Нөмрөг-Түдэвтэй сумын 35 кВ-ын 45 км ЦДАШ, 1х1, 1х0,1, 1х0,25 мВА дэд станц /Завхан/2007-2008	1 100 000,0	644 124,9	45	38			7,0	114405,0
40	Арцсуурь боомт-Тэс сумын 10 кВ-ын 36 км ЦДАШ, 1х0,1, 1х0,16 мВА дэд станц /Завхан/ 2007-2008	400 000,0	301 572,6	36	35,4			0,6	5738,2
41	Алдархаан- Эрдэнэхайрхан 35 кВ-ын 100 км ЦДАШ, 1х1 1х0,1, 1х0,16 мВА дэд станц /Завхан/ 2007-2008	2 100 000,0	1 505 588,2	100	85,24			14,76	253736,3
42	Улиастай-Яруу сумын 35 кВ-ын 60 км ЦДАШ, 1х1,0 1х0,16 мВА дэд станц /Завхан/ 2007-2008	1 330 000,0	1 015 046,2	60	57,5			2,5	48290,8
<b>Дүн</b>						<b>66,58</b>	<b>1065427,4</b>	<b>332,3</b>	<b>4947280,6</b>



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН ТУШААЛ

2009 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 73

Улаанбаатар хот

Гүйцэтгэлийн аудитын тайланг  
баталгаажуулах тухай

“Төрийн аудитын тухай хууль”-ийн 13.4.5, “Гүйцэтгэлийн шалгалтын журам”-ын 23.2, “Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам”-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг.Дэд бүтцийн салбарт улсын төсөв, МУХС, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2008 онд хийсэн хөрөнгө оруулалтын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, тайлагнал, түүний үр дүнд хийсэн аудитын тайланг баталсугай.

Хоёр.Аудитаар илэрсэн төлбөр, зөрчлийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

Гурав.Аудитын тайланг Эрдэс баялаг, эрчим хүчний болон Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яаманд хүргүүлсүгэй.

Дөрөв.Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2009 оны 11 дүгээр сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга нарт зөвлөсүгэй.

Тав. Аудитын тайланд тусгагдсан зөрчлийн барагдуулалт, зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон Удирдлагын зөвлөлд танилцуулж ажиллахыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д. Ганбилэгт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР

Ч.РАДНАА

Хуулбар үнэн:

ТАМГЫН ГАЗРЫН  
ЗАХИРАЛ

 С.ЛХАГВАСҮРЭН

070118

Дэд бүтцийн салбарт улсын төсөв, МУХС, гадаадын зээл, тусламжийн  
хөрөнгөөр 2008 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт,  
түүний үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар илрүүлсэн  
төлбөр, зөрчлийн жагсаалт

(мянган төгрөгөөр)

д/д	Хариуцагч байгууллага	Төлбөр, зөрчлийн агуулга	Төлбөрийн дүн	Зөрчлийн дүн
1	Газрын тосны газар	Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын лабораторын тоног төхөөрөмжийн 1387300.2 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон, гэрээний хугацаа дууссан боловч өнөөг хүртэл нийлүүлээгүй		1 387 300,2
2	Эрчим хүчний газар	Өмнөд дэд станцын шинэчлэлийн ажил, Нүүрсний хими технологийн туршилт судалгааны лабораторийн барилга угсралт, тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалтын бүрэн хийгдээгүй ажлыг дууссаагаар тооцож, гүйцэтгэл гаргасан		3 328 953,8
3	ЭБЭХЯ	ЦДАШ-ын БУА-ын гэрээний дагуу санхүүжилт авсан 4947.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ЦДАШ-ын урт ажлын зурагт тусгагдсанаас зөрүүтэй гарсан тул 332.3 км 4947.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий ЦДАШ-ын БУА-ын тооцоог дахин нягтлан шалгах ажлыг зохион байгуулж улсыг хохиролгүй болгох		4 947 280,6
4	ЭБЭХЯ ЭХГ	Баян Өлгий аймгийн Цагаан нуур-Ногоон нуур сумын 35 квт-ын ЦДАШ-ын ажлын гүйцэтгэл 15203.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгуулахаар, Сангийн яамнаас ЭХГ-т 2008 оны 12 дугаар сарын 27-нд болон 28-нд давхар шилжүүлсэн тул улсын төсөвт буцаан төвлөрүүлэх	15 203,0	
5	ЭБЭХЯ	2008 онд улсын төсвийн хөрөнгөөр 1189.6 сая төгрөгийн ЭХ-ний зураг, төсөл, ТЭЗҮ, хайгуул судалгааны ажил хийгдэж санхүүжигдсэн боловч Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын 4.47-д "Биет бус хөрөнгөд . . . судалгаа хөгжүүлэлтийн зардал орно", 4.48-д "Биет бус хөрөнгийг анхны үнээр бүртгэнэ" гэж заасны дагуу биет бус хөрөнгөд бүртгээгүй.		1 189 600,0
6	Дэлхийн банкны зээлийн санхүүжилттэй Эрчим хүчний төсөл	Төслөөс хэрэгжүүлж буй УБЦТС ТӨХК-ийн Сонгинохайрхан салбарын түгээх сүлжээний шинэчлэлийн БУА-ын гүйцэтгэгч Алтай трест ХХК-ийн ажлын гүйцэтгэл дутуу, гэрээний дагуу хариуцлага тооцоогүй.		657 300,0

tushaal

7	ЗТБХБЯ	Улсын төсөв, гадаадын эзэлийн эх үүсвэрээр баригдаж, улсын комиссын актаар 2007 онд ашиглалтад орсон 47.8 км хатуу хучилттай, 46.0 км хайрган хучилттай авто замыг нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэлд тусгаагүй.		11 272 966,5
8	ЗТБХБЯ	"Нутгийн зам" ХХК-д банкны хуурамч баталгааг үндэслэн 657.0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон, "АСБИ" ХХК-д 235.9 сая төгрөгийн урьдчилгаа санхүүжилт олгосон боловч өнөөг хүртэл гүйцэтгэл гаргаж баталгаажуулаагүй.	893 700,0	
9	ЗТБХБЯ	Төсвийн хөрөнгө оруулалтын дансны 2008 оны жилийн эцсийн үлдэгдлийг улсын төсвийн дансанд төвлөрүүлээгүй	415,5	
		<b>ДҮН</b>	<b>909 318,5</b>	<b>22 783 401,1</b>

tushaal